



---

# МОНГОЛЫН АНАГААХ УХААН

---

1993. 2

---

**MONGOLIAN MEDICAL SCIENCES  
QUARTERLY JOURNAL OF THE MINISTRY OF  
HEALTH, MONGOLIA AND THE SCIENTIFIC  
SOCIETY OF MONGOLIAN PHYSICIANS**

34-th year of publication No. 2 (83)

1993

**CONTENTS**

**HEALTH POLICY**

- P. Nymadawa, B. Nambar, A. Busma**  
Natural Environment and Health 3

**ORIGINAL ARTICLES**

- A. Ulzilkutag, Ts. Altannavch**  
Lipid Metabolism of Population in the different Regions of Mongolia 7
- D. Amgalanbaatar, B. Dagdambazar**  
Dynamics of Formation definitive Constrictions of myocardial microvessel Nets in conditions of chemical desym-pathysations of Rats in postnatal Ontogeny 11
- Ts. Lhagvasuren**  
Changes of blood hormones and uptake of iodine by thyroid gland of patients with diffuse thyrotoxicosis 19
- D. Baasanjav, G. Dolgor**  
On the Question of Epidemiology of risk factors for disorders of cerebral blood circulation among definite Population Group 25
- A. A. Merunko, N. Baasanjav, B. B. Pekarskii**  
Clinical application of new method of vital staining of heart conduction system during open-heart surgery 31
- I. Purevdorji**  
Interconnection of fingerprints and ability of learning for students 34
- G. Batbaatar, B. Bayart**  
Research of the Neutrophils phagocytizing activity of the Mongolian people in healthy and pathological conditions 37
- D. Enkh-Amar, B. Bayart**  
Study of T-lymphocytes subpopulations of the Mongolian people in healthy and pathological conditions 40
- B. Shijirbaatar, B. Jav, Comdiya Suriya**  
Clinical Prognosis of Extrauterine destation 42

**LECTURES, REVIEWS AND CONSULTATIONS**

- G. Sukhbat, O. Amartsengel**  
Application of psychophysiological tests in Selection of medical specialists 45
- A. B. Khvatova, E. Sanja, M. Enkhtuu**  
Some questions of Eyetrauma of Children 49
- D. Amgalanbaatar, S. Taimjidma, S. Tundevrentsen**  
Analysis of adult sudden Death 51
- B. Natsagdorji, B. Dagvadorji, Ja. Dagyadorji**  
The Methods of Liver Biopsy 53

**EVENTS**

- G. Tsetsegdari**  
South-East Asian Regional Conference on medical education 60

## ГАРЧИГ

### Эрүүл мэндийн бодлого чиглэл

П. Нямдаваа	Б. Намбар	А. Бузмаа	
	Байгаль орчин-эрүүл мэнд		3
<b>СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ</b>			
А. Өлзийбат	Ц. Алтаннавч		
	Монголын газарзүйн янз бүрийн бүсэд оршин суугчдын лишидийн солилцооны байдал.		7
Д. Амгаланбаатар	Б. Дагданбазар		
	Ургал мэдрэлийн (симпатик) тэжээх тогтолцоо дарангуйлагдсан нөхцөлд хархны зурхний булчингийн бичил эргэлтийн торны төрөлжлөгдсөн загвар бүрэлдэх үйл явцын онцлог		11
Ц. Лхагвасүрэн	Тархмал хордлогот бахлууртасын үед бамбай булчирхайн иод шингээх чадвар болон цусан дахь дааврын өөрчлөлт		19
Д. Баасанжав	Г. Долгор		
	Тодорхой хүн амын дунд тархины судасны өвчнийг нөхцөлдүүлэгч хучин зүйлийн тархалтын асуудалд		25
А. А. Мерунко	В. В. Пекарский	Н. Баасанжав	
	Нээлттэй зурхний мэс заслын үед зурхний мэдрэлийн дамжуулах судлын бие зүйн тогтоцыг тодорхойлох арга		31
И. Пүрэвдорж	Гарын хээ ба сурах чадварын хоорондын хамаарал		34
Г. Батбаатар	Б. Баярт		
	Хүний нейтрофил эсийн залгих чадварыг эрүүл ба эмгэг үед судалсан нь		37
Д. Энх-Амар	Б. Баярт		
	Монгол хүний Т лимфоцитын дэд бүлгийг эрүүл ба эмгэг үед судалсан нь		40
Б. Шижирбаатар	Б. Жав	Сомдия Суря	
	Умайн гадуурхи жирэмсний эмнэлзүйн тавилан.		42

## ЛЕКЦ ТОЙМ ЗӨВЛӨГӨӨ

Г. Сүхбат	О. Амарцэнгэл	
	Мэргэжил сонголтонд сэтгэц физиологиин сорил хуртлэх алхам	45
М. Энхтуул	А. В. Хватова Э. Санжаа	
	Хүүхдийн нүдний гэмтлийн зарим асуудалд	49
Д. Амгаланбаатар	С. Тамжидмаа С. Түндэврэнцэн	
	Насанд хүрэгсдийн гэнэт нас барсан тохиолдолд хийсэн шинжилгээний дунгэр	51
Б. Нацагдорж	Б. Дагвадорж Я. Дагвадорж	
	Элэгний эд эсийг шинжилэх аргачлал	53
<b>ҮЙЛ ЯВДАЛ</b>		
Г. Цэцэгдарь		
	Зүүн өмнөт Азийн Бусийн зөвлөгөөн	60

## МОНГОЛЫН АНАГААХ УХААН СЭТГҮҮЛИЙН ЦЭЦИЙН ГИШҮҮД

П. Нямдаваа (өрөнхий эрхлэгч), Б. Дэмбэрэл (I орлогч эрхлэгч), Г. Дашзвэг (орлогч эрхлэгч), Ш. Доржжадамба (орлогч эрхлэгч), Г. Пүрэвдорж (хариуцлагатай җарийн бичгийн дарга), Р. Арслан, Ж. Батсуурь, Б. Гоош, А. Ламжав, Э. Лувсандаавга, А. Өлзийхутаг, Т. Тойвгоо, Ц. Хайдав, Ж. Шагж, Б. Шижирбаатар, Г. Цагаанхүү.

## ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

С. Алтан (АНУ, Нью-Жерен), Д. Балдандорж, Б. Банзар, М. Грэйт (АНУ, Миннесота), Д. Дагвацэрэн, Ж. Дашдаваа, Б. Доржотов, Б. Жав, Г. Жамба, Ш. Жигжидсүрэн, Г. Зоригт, Т. Зориг, Г. Лувсан (оросын холбоо Москва), Д. Малчинхүү, Н. Мөнхтүвшин, Ц. Мухар, Б. Нацагдорж, Ц. Норовпил, Ч. Нээчин, П. Онхуудай, Э. Пүрэвдаваа, Б. Рагчаа, Э. Санжаа, Г. Сүхбат, С. Цоодол, Л. Шагдар.

**МАНАЙ ХАЯГ, УЛААНБААТАР 210618  
ЧИНГИСИЙН ӨРГӨН ЧӨЛӨӨ  
«ЭРҮҮЛ ЭИХ» ХЭВЛЭЛИЙН ГАЗАР. УТАС 21307**

# Эрүүл мэндийн бодлого чиглэл

## БАЙГАЛЬ ОРЧИН-ЭРҮҮЛ МЭНД

П. Нямдаваа, Эрүүл мэндийн яам,  
Б. Намбар, А. Бүзмаа рашаан судлалын төв

Хүрээлэн байгаа орчин хүний амьдралын уйл ажиллагааны бүх л талыг, ингэхлээрээ хүний эрүүл ба эмгэг байдлыг эхцөлдүүлэх гол гадаад хүчин зүйл болно. Тиймээс өвчин эмгэг гэдэг бол хүний бие махбод гадаад орчинтойгоо дасан зохицож чадахгүй байгаагийн илрэл гэж тодорхойлох явдал ч байдаг.

— Хүний бүх л өвчин, эмгэгийг дотоод (эндоген), гадаад (экзоген) шалтгаант гэж хуваан үзэж болох бөгөөд гадаад шалтгаант [эмгэгийг];

— байгалийн хүчин зүйлээс шалтгаалсан;

— хүний өөрийнх нь бий болгосон орчны (техноген) хүчин зүйлээс шалтгаалсан гэж ангилж болно.

Байгалийн хүчин зүйлээс шалтгаалсан эмгэгийг;

— геофизикийн хүчин зүйл (нарны цацраг, агаарын даралт болон халуун хүйтэн, салхины хүч, тунадасны хэмжээ г. м)-ээс шалтгаалсан;

— геохимийн хүчин зүйл (хөрс, усны химиин найрлага)-ээс шалтгаалсан;

— хоол тэжээлийн дэглэмтэй холбоотой;

— хорт ургамал, ургамлын харшилтөрөгч (аллерген)-тэй холбоотой;

— хорт амьтан, амьтны гаралтай харшилтөрөгчтэй холбоотой;

— амьд үүсгэгч нян)-ээр сэдээгдэн

— байгалийн гамшигтай холбогдсон гэж ангилдаг (А. Г. Воронов, 1981).

Харамсалтай нь хүн амын өвчлөл, эндэгдлийг тус орчны янз бурийн хэсгийн байгаль, цаг уур, газар зүйн нэхцэл, онцлогтой холбон судалсан материал манайд харьцангуй бага байна. Улаан хоолой ходоодны өмөнгийн өвчлөлийг монголчуудын хэт халуун хоол, цай хэрэглэх зуршилтай холбон судалсан (Б. Доржготов, 1989), уулархаг ландшафт хүн амын зүрх судас, амьсгалын тогтолцооны уйл ажиллагаанд өвөрмөц нөлөөлдгийг судалсан (Г. Батмэнх, 1981, Л. Өлзийхутаг, 1990), ус хэрсэн дэх фтор, иод зэрэг бичил махбодын агууламж нь флюороз, нутагшмал бамбайдал зэрээг зарим эмгэгийн үүсэл, хөгжилтэй холбоотойг судал-

сан (Д. Дорж, 1990), зарим ургамлын тоос Улаанбаатар хотод харшлын өвчиний шалтгаан болж буйг судалсан (Б. Сангидорж, 1990) тэдийгээр энэ талын судалгаа хязгаарлагдаж байна.

Байгалийн голомтот халдвартын тухайд тус улсын 16 аймгийн 140 орчим сумын 628000 км<sup>2</sup>/квадрат талбайд тархсан тарваган тахлын голомтоос (Б. Батсүх, Ц. Чулуунбаатар, 1986; Е. П. Голубинский, 1988); гадна нутгийн умарг, төв хэсгийн дийлэнх хэсэгт ку-чирэгийн (Б. Бямбаа, 1984), умарг хэсгийн зарим бүсэд хачигт энцефалитын, дорнод хэсэгт гета-вирусийн байгалийн голомг байгаат илрүүлж тогтоогоод (Д. Абмэд нар, 1990 а, 190 б) байна. Мөн тус улсын нийт нутаг дэвсгэрт нэн тархмал байгаа вируст гепатит, нэн ялангуяа В. гепатит, түүнээс уламжилсан элэгний анхдагч эмнөнг (П. Нямдаваа, 1984; П. Нямдамаа 1989;), манай орны хувьд нутагшмал (эндемик) эмгэг хэмээн үзэх үндэстэй. Цаашдаа бус нутгийн уугуул хүн амын хэвлийн үйл ажиллагааны онцлог, өвчлөл эндэгдлийн байдлыг тухайн газар орны байгаль цаг уур, газарзүй, экологийн онцлогтой холбон судалж, шалтгааны дагаварын хэлжээг тогтоон, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх аргыг боловсруулах нь эрүүл мэндийн салбарын одоогийн шатны нэн тулгамдсан асуудлын нэг болж байна.

Нөгөө талаар байгаль орчны хүчин зүйлс нь хүн амыг өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх асар их нөөций бололцоо юм.

Байгалийн эрүүлжүүлэх хүчин зүйлээс харьцаангуй сайн судлагдсан, тодорхой хэмжээгээр эрүүл мэндийн чиглэлээр ашиглагдаж буй нь эрдэст ус, шавар (рашаан, рашаант шавар) болно. Тус улсын нутаг дэвсгэрт рашааны шинжтэй 400 шахам ус байгаагийн 100 гаруй нь олон улсын стандартын шаардлага хангахуйц рашааны орд ажээ. (О. Намнандорж нар, 1966; Е. В. Пиннекер нар, 1980; Л. Одончимэд, Л. И. Баклыков, 1985, И. Шима нар, (1990) Олон улсын стандарт хангаж буй рашааны ордны 40 хувь орчим нь халуун рашаан, үлдэх нь нүүрсхүчлийн хийтэй булгийн үндартын хийсэн тооцооноос үзэхүйтэн рашаан болно. Судлаачдын хийсэн тооцооноос үзэхүйтэн рашаан булгийн үндартын хийтэй хүйтэн рашааны булгийн үндартын нийт хүчин чадал нь 33 л/сек болж буй ажээ. Гэтэл бид мэдэгдэж буй рашааны ордноосоо дөнгөж наймыг нь улсын чанартай рашаан сувиллын хэлбэрээр ашиглаж байгаа нь тун учир дутагдалтай байна. Цаашид

улсын эрдэст ус, шаврын нөөц, үйлчилгээний зохистой даацын үнэлгээг шинжлэх ухааны үндэстэй тооцон гаргаж, рашаан сувиллыг цаашид хөгжүүлэх ерөнхий чиглэлийг боловсруулан хэрэгжүүлэх нь хүн амын эрүүл мэндийг бэхжүүлэх, эрүүлжүүлэх хойшлуулшгүй зорилт болохын зэрэгцээ улс орны эдийн засгийн чадавхид ч зохих хувь нэмэр оруулах нөхцөл бололцог бурдуулэх ирээдүйтэй юм.

Тус орон дахь байгалийн эмчилгээний өөр нэг ирээдүйтэй чиглэл бол агаар эмчилгээ болно. Хангай, Хэнтий, Саяан дунд уулсын шилмууст сийтой өндөрлөгүүд нь жилийн диймэнх хэсэгт (жилд 250-иас дээш өдөр) наартай байдаг нь уушгины архаг үрэвсэл, гуурсан хоолойн багтрааг эмчлэх асар их нөөц юм. Харамсалтай нь бид энэ их нөөцийг бараг огт ашиглахгүй байна. Цаашидаа байгалийн үзэсгэлэн бурдсан дунд уулсын бүсийг энэ чиглэлээр идэвхтэй ашиглах болдого боловсруулан хэрэгжүүлэх щаардлагатай байна. Гадаадын зарим орны туршлагаас үзвэл агаар эмчилгээний чиглэлд манай оронд огт хөндөгдөөгүй нэг чиглэл бол агуяа засал болно. Газарзүйчид, агуяа судлаачдын идэвхтэй оролцостойгоор тус орны нутаг дэвсгэр дэх агуяа цэс гаргаж, агаарынх нь найрлатыг судлан тогтоосны үндсэн дээр эмчилгээний зориулалтаар ашиглаж болох агуяа жагсаалтыг гаргах нь энэ чиглэлийн судалгааны эхний алхам болох ёстой.

Манай орны нөхцөл дэх байгаль эмчилгээний өөр нэг ирээдүйтэй чиглэл бол элс-нарчы угайл юм. Сүүлийн арваад жилд манай эмч, мэргэжилтийн Гөсвь-Алгайн Бигэр, Дорноговийн Таван манхан, Баянхонгорын Эхийн голд хийн эн эмнэлээд ажиглалтаас үзэхэд бөөрний архаг эмгэгтэй хүмүүсийг зуны улиралд элс-нарчы угаглазар зруулжүүлэх нь ихээхэн үр дүнтэй байна. Энэ өвөрмөц эмчилгээний эмнэлэг биологийн үндэслэлийг орчим үеийн анагаах ухааны түвшинд баталгаажуулбал энэ нь дэлхийн анагаах ухааны сан хөмрөгт蒙古лын эмч, эрдэмтдийн оруулсан Бодитой хувь нэмэр болж, цаашидаа олон орны эмч эрдэмтэй, мөн өвчтөний сонирхон тэмүүлэх газар болохыг угуйсгэх аргагүй байна.

Манай орон байгалийн үзэсгэлэн бурдсан онгон тансаг газар олонгийн нь цэцэг ногооны анхилуун үнэр, байгалийн уянгалаг хөгжимтэйгээ хослоод хүний сэрэхуйн бүх л эрхтэнд гоо сайхны дахин давтагдамгүй сэрэл үүсгэх ер бусын ид шидтэй нь байгалийн эмчилгээний бас нэг шавхатдашгүй нөөц болно. Хотжилт, үйлдвэржилтийн түрлэгээр ихсэх хандлагатай сэтгэл, мэдрэлийн ачаалал, түүнээс уламжил-

сан эмгэгээс сэргийлэх, анагаахад гоо сайхны эмчилгээний энэ хэлбэр улам бүр ач холбогдолтой болж байна.

Байгаль орчны иж бүрдмэл эрүүлжүүлэх үйлчлэлээс гадна манай орны ургамал, амьтан, эрдсийн сан нь эмийн үйлдэлтэй босисоор арвин баян юм. (Ц. Хайдав, 1977; Ц. Хайдав нар, 1975, 1985, Г. Зориг, 1985, 1989). Байгалийн эдгээр баялагийн тархац нөөц нэхэн сэргээгдэх зүй тогтлыг ул суурьтай судалсны үндсэн дээр эх орны эмийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хүн амын эрүүл мэндийн үйл чилгээнд нэвтрүүлэх, паashiid дэлхийн зах зээл дээр гаралт арга замыг хайх нь манай судлаачдын нэгэн чухал зорилт болж байна.

Манай орны байгаль орчны эрүүлжүүлэх гайхамшигт нөөцийн тухай ярихдаа бид хүний өөрийнх нь ажиллагааны уршгаар байгаль орчны эрүүл мэндэд зэрэг нэлөөлөх хүчин зүйлс сөрөг үйлчилгээтэй болж эхэлж байгааг дурдахгүй байх аргатгуй юм.

Энэ нь юуны өмнө төв суурин газрын бохир усыг цэвэршүүлэх үйл ажиллагаатай холбогдоно. Манай судлаачдын (Ё. Банзар, 1979; Д.. Галбадрах, 1989) хийсэн ажиглалтаас үзэхэд Улаанбаатараас эхлээд тус орны төвлөрсөн хот, сууринаас гарч буй бохир ус нь үйлдвэрийн хорт хольц, өвчин үүсгэгч нян, вирусийн бохирдлоос бүрэн цэвэршигүй байгаа нь төв суурин газарт гэдэсний халдварт өвчин зэрэг зарим төрлийн эмгэг дэлгэрмэл байгаагийн нэг шалтгаан болж байна.

Улаанбаатар, Шарын гол зэрэг зарим хотуудын атмосферийн агаарт ялангуяа өвлийн улиралд хорт хольцын хэмжээ нь эрүүл ахуйн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс олон дахин давж, амьсгалын замын өвчлөл ихсэхэд нэлөөлж байгааг судлаачид (Н. Сайжaa нар, 1982, 1986) бичсэн байна.

Иймээс байгаль орчны болон эрүүл ахуй, халдварт судалыг хяналтын байгууллагуудын иж тулгамдсан зорилт нь улс орчны үйлдвэржүүлэх явцад байгаль орчныг бохирдуулах буюу байгалийн хүчин зүйлийн эрүүлжүүлэх хүчин чадлыг буурвуулж ботлошигүй үйлдвэрлэлийн технологийг цэвэршүүлэхгүй байхат чиглэсэн судалгаа, хяналтыг өргөжүүлэх явдал болж байна.

Тус орчны ижтээм эдийн засгийн хөгжлийн цогцолбор төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх явцад байгаль орчны эрүүлжүүлэх нөөцийг бүрэн дүүрэн ашиглах, чадавхийг нь ширгээхгүй байхад чиглэсэн бодлого боловсруулан хэрэгжүүлэх нь байгаль орчны хяналтын болон эрүүл мэндийн байгууллагуудын хойшлуулашгүй зорилт мөн.

## Судалгаа шинжилгээ

### МОНГОЛ ОРНЫ ГАЗАРЗУЙН ЯНЗ БУРИИН БҮСЭД ОРШИН СУУГЧДЫН ЛИПИДИЙН СОЛИЛЦООНЫ БА ДАЛ

А. Өлзийхутаг, Ц. Алтаннавч

ХХ зууны эхээр зурх судасны өвчлөлийн дото «липидийн солилцооны хямрал, зурх судасны гажуудал» хоёр анагаах ухаанд тулгамдсан асуудлын нэг болон гарч шинжилгээ судалгааны гол чиглэл болсон. Даалаад жилийн тэртээ Оросын эрдэмтэн Н. Н. Аничков, С. С. Халатов (1912) нар анх «Липидийн солилцооны хямралын ур дагавар нь атеросклероз өвчин юм» гэсэн ойлголт дэвшүүлсэн нь шинжлэх ухаанд томоохон алхам болсон юм. Түүнээс хойш олон орны судлаачид энэ чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил байнга хийж байгаа боловч тайлбарлагдаагүй зүйл байсаар л байна. Тухайлбал: хүний артерийн судасны хананд липид хуримтлагддагийн гол шалтгаан, сэдээх хүчин зүйл, механизмын талаар судалгаа үргэлжилж байна.

Сүүлийн үед лицидийн солилгооны хямралд хүрээлэн байгаа гадаад орчны нөлөөлэл, хумусийн аж амьдралын хүчин зүйлс хамаатай гэсэн ойлголт их яригдах боллоо. (Но. Дондог 1963, Лувсанноров 1970, Эллиот В., Кенней М. 1975)

Иймээс бид энэ удаа монгол орны байгаль газарзүйн янз бурийн бүсэд байрладаг Улаанбаатар хот, (1200—1350 м), Дорнот (800—1000 м), Өвөрхангай-Хужирт (1200—2200 м) зэрэгт оршин суугчдын цусны ийлдэс дэх липидийн солилцоог судлах зорилгоор нийт холестерин, альфа-холестерин, триглицеридын дундаж хэмжээг гаргаж хсоронд нь харьшуулан наасны булэглэлээр нь дүгнэв.

#### Судалгааны арга

Судалгааг Улаанбаатар хотод (1200—1350 м далайн төвшөөс дээш) нийт 383 хүнд, Дорнод аймагт (800—1000 м) 145 хүнд, Өвөрхангай аймагт (2000—2200 м) 41 эрүүл гэгдэх 35—60 наасны эрчүүдийн дунд хийв.

Цусны ийлдэсийг центрифугээр салтаж, нийт холестерин, альфа-холестерин, триглицеридийг тодорхойлох хүртлээ 15° С-т хадгалсан. Шинжилгээг Клиникийн III эмнэлгийн лабораторит хийж, цусны ийлдэс дэх нийт холестерин, альфа-холестерийнийг ДЭМБ-ын мэргэжилтнүүдийн томь-

ёолсон Л. Л. Абелл (1952) аргаар тодорхойлж, триглицеридийг Л. А. Карлсон (1963) аргыг ашиглан гүйцэтгэв.

### Судалгааны дүн

Хүмүүсийн цусны ийлдэс дэх нийт холестерин, альфа-холестерин, триглицеридийн дундаж хэмжээг 10 наасны бүлгээр нь ялгаж хүснэгтэнд оруулжээ. (Хүснэгт 1)

Хүснэгт №1-ээс үзэхэд Улаанбаатар хотын оршич суугчдын цусны ийлдэс дэх нийт холестерин, триглицеридийн хэмжээ их бус, ДЭМБ-ын тогтоосон хэвийн хэмжээний түвшинд байгаа нь харагдаж байв.

Тухайлбал: нийт холестерин, триглицеридын хамгийн их хуримтлагдаж болох 45-аас дээш насны хүмүүст авч үзвэл; нийт холестерин, 15—54 насанд  $5,2 \pm 1,12\%$ , 55—64 насанд  $5,02 \pm 1,02\%$  тус тус тодорхойлогдоо. Дорнод аймагт хийсэн цусны шинжилгээнд дээрхи үзүүлэлтүүд их бус ДЭМБ-ын хэвийн хэмжээнд байгаа боловч Улаанбаатар хотынхтой харьцуулахад 1,8%-иар бага, 55—64 насанд  $0,68 \pm 0,18\%$  буюу 0,7%-иар тус тус бага хэмжээтэй тодорхойлогдов. Өвөрхангай аймагт хийсэн шинжилгээнээс үзэхэд тэндхийн хүмүүсийн цусны ийлдэс дэх нийт холестерин, триглицеридийн хэмжээ их бус хэвийн түвшинд байв. Харин 45-аас дээши насанд нийт холестерины хэмжээ Улаанбаатарын хүмүүсийнхээс арай бага байлаа. Тухайлбал; нийт холестерин 45—54 насанд  $4,75 \pm 1,02\%$  байгаа нь хотын хүмүүсээс 1,8% бага хэмжээтэй харагдлаа.

Хүснэгт №2-оос үзэхэд Өвөрхангай аймгийн хүмүүст 45—54 насанд  $1,32 \pm 0,40\%$ , 55—64 насанд  $1,35 \pm 0,16\%$  байгаа нь Улаанбаатар, Дорнодын хүмүүсийн цусны ийлдэс дэх альфа-холестерины хэмжээтэй ойролцоо буюу ДЭМБ-аас тогтоогдсон хэвийн түмшинд байна,

Судалгаанд хамрагдсан бус нутгийн хүмүүсийн цусны ийлдэс дэх нийт холестерин, альфа-холестерин, триглицеридийн хэмжээ ДЭМБ-аас тогтоогдсон хэвийн хэмжээний түвшингт байгаагаас үзвэл манай орны хүмүүсийн липидийн солилцоонд бидний хэрэглэдэг амьтны гаралтай өөх тостой зүйл бага нөлөөлдөг бололтой Энэ нь манай орны хүмүүсийн амьдралын дадал заншил, ажил төрлийн онцлоггоос бөхсөн амьзарч байгаа байгаль газар зүйн онцлог зэргээс хамааралтай байж болж мэт.

Тухайлбал: 1) Улаанбатар хот далайн түвшнээс 1200—1350 м өндөрт оршидог, сард агаарын температурын хэлбэлзэл 45,7 хэм; агаарын дундаж Р—653,8 мм МУБ, Хотын хүн ам нийлээд шигүү суурьшсан, аж үйлдвэрлэл хөгжсөн ба хоол хүнсэндээ ногоо, чихэрлэг зүйлс (нүүрс ус ихтэй) харьцангуй их хэрэглэдэг байхад Дорнот аймаг далайн

түвшнээс 800—1000 мөндөрт оршдог, ёрөнхийдөө нутағ нь талархаг. Жилд дунджаар 170—175 мм хур тунадас бууна. Жилийн дундаж температур (+) байdag ба зуны улирал +20 хэм, өвлийн дундаж  $T = -20$  хэм орчиим байdag юм. Нутгийн хүмүүс нь хотынхосс илүү сүү, сүүн бүтээгдэхүүн хэрэглэдэг ба ногоо, чихэрлэгт зүйлс, давс бага хэрэглэнэ.

Өвөрхангай (Хужиртын хойт хэсэг) 2000—2200 м өндөрт оршдог ба жилийн дундаж  $T = -0,2 - 0,3$  хэм хуртэл хэлбэлзэнэ. 1 сарын дундаж  $T = -23$  хэм, жилд дунджаар 250—350 мм хур тунадас буудаг Хүмүүс нь өөх тос, давс ихтэй коол, цай хэрэглэдэг онцлогтой, нүүрс ус бага хэрэглэдэг юм байна. Энэ байдлаас харагад Улаанбаатарчууд аж амьдрал, ажил хөдөлмөр нь европжсон ба липидийн солилцооны үзүүлэлтүүдийн түвшин ч ДЭМБ-аас тогтоосон хэвийн хэмжээнд хүрч байна. Харин Дорнот аймагт хүмүүс нь хоол хүнсэндээ нүүрс ус, давс бага хэрэглэдэг нь липидийн солилцооны үзүүлэлтийн дундаж түвшин ДЭМБ-аас тогтоогдсон хэмжээнээс хэт доогуур болох шалтгаан болж матагдгүй байна.

Өвөрхангай (Хужирт сумын хойд хэсэг) аймагт өндөр уулын бүсийн цаг агаар, уур амьсгал нь хүмүүсийнх нь хэрэглэдэг их өөх тостой бас давстай хоол, цайтай нь энерги зарцуулалтын шаардлагаас урган тарсан байж болох бөгөөд, тэр нутагт өөх тос түргэн исэлдэх талтай байж болох ба нөгөө талаар энэ нутгийнхан бас нүүрс ус бага хэрэгдэлэг нь холестериний дотоод синтез бага байх нөхцөлийг бурдуулж лицидийн солилцооны хямралд хургэхгүй байж болох мэт. (Самсонов 1979)

Үүнээс үндэслэн манай орны хүн амын хоол тэжээлд голчлон амьтны гаралтай өөх тостой бүтээгдэхүүн эзэлтэг боловч, цусны ийлдэс дэх липидийн солилцооны хямрал хоол хүнсээр биед орох өөх тосноос бага хамааралтай болох нь Дорнод, Өвөрхангай аймгийн хүмүүсийн судалгаанд ажиглагдав. Харин Улаанбаатар хотын оршин суугчдын цусан дахь лицидийн түвшин Дорнод, Өвөрхангай аймгийнхыг бодвол арай их хэмжээтэй байгаа нь хотын хүмүүс хүнс тэжээлдээ чихэрлэгийн зүйл (нүүрс ус) илүү хэрэглэдэг нь сиолын дагуу хоол хүнсэн дэх холестерин, триглицеридийн нөлөөнөөс гадна холестерин дотор эрхтэнд нийлэгжих үзэглэл илүү байгаатай холбоотой гэж үзэж боллооор байна. Манай оронд атеросклероз өвчин түүний үр дагавар ховор, явц нь зөвлөн байдаг тухай судалгааны гол тайлбар эндээс ч гарч болох юм. (Но Дондог 1967, Галцог 1975)

Цаашид манай орны нөхцөлд липидийн судалгааг нарийвчлан судлах нь түүний хямралын гол үр дагавар болох атеросклероз өвчинэс урьдчилан сэргийлэх, зөв оношлех, эмчлэх асуудалд чухал ач холбогдолтой байна. Цусан дахь липидийн дундаж түвшин тус орны байгаль газарзүйн энэ хэдэн бүсэд хэвийн хэмжээнд байгааг авч үзвэл бил тус оронд атеросклероз гэж оношлох асуудал дэлгэрэнгүй байгааг авч үзүүштэй байна. Бидний онош зөв үү? Эсвэл атеросклероз уу? Манай орны нөхцөлд байгаль цаг уур, аж амьдралын өвөрмөц нөхцөл онцлогогоос болж цусан дахь лицид хэтэрч исэлдэх, судасны хананд менираль бодис идэвхтэй нэвчиж, хуримтлагдах зэргээс болж атеросклероз давамгайлдаг байж болзошгүй байгаад анхаарлаа төвлөрүүлэх нь зүйтэй юм. Үүнтэй холбогдуулан тус орны хүмүүст микро, макро элементийн солилцооны болон антиоксидантын талаар судалгаа чухал шаардлагатай байна.

### Дүгнэлт

1. Монголын байгаль газарзүйн янз бурийн бүсэд оршдог (Улаанбаатар, Дорнод, Өвөрхангай) хүмүүсийн цусны ийлдэс дэх нийт холестерин, альфа-холестерин, триглицериидийн дундаж хэмжээ харилцан адилгүй байча. Тухайлбал: Улаанбаатарчуудын цусны ийлдэс дэх нийт холестерин, альфа-холестерин, триглицериидийн дундаж хэмжээ ДЭМБ-аас тогтоосон хэмжээний түвшинд байхад, Өвөрхангай аймгийнханы липидийн дундаж түүнээс доогуур байна. Дорнот аймагт липидийн солилцооны дундаж үзүүлэлт нилээд доогуур түвшинтэй ажиглагдаж байна.

2. Монголчуудын цусны ийлдэс дэх липидийн зарим дундаж үзүүлэлт харилцан адилгүй байгаа нь нутгийн хүмүүсийн хоол, тэжээлийн онцлог, амьдралын дадал заншил, байгаль цаг уурын өвөрмөц тогтолцостой холбоотой харилцан адилгүй өөр өөр байгаа нь тодорхой байна.

3. Монголчууд амьтны гаралтай өөх, тос их хэрэглэдэг нь липидийн солилцооны дундаж түвшинг хямраадаггүй, өндөр уулын хатуу ширүүн уур амьсгалд тэрээр амархан исэлдэж ангидирдагийн (шингэлдэг) зэрэгцээ, биеийн дотор үүсэх холестериний гол эх үүсвэр-нүүурс усыг нутгийн хүмүүс бага буюу огт хэрэглэдэггүй нь липидийн солилцооны хямралд хүргэдэггүй бололтой.

Цусны ийлдэс дэх липидийн солицооны зарим үзүүлэлтүүд  
(Хүснэгт 1)

Насны бүлэг	Нийт холестерин						Триглицерид					
	Улаанбаатар		Дорнот		Өвөрхангай		Улаанбаатар		Дорнот		Өвөрхангай	
	M	±	M	±	M	±	M	±	M	±	M	±
35—44	136	5,3± 1,23	73	4,71± 0,95	14	5,13± 1,07	120	1,12± 0,68	74	0,79± 0,75	14	1,02± 0,54
45—54	150	5,2± 1,12	46	4,8± 0,96	17	4,85± 0,94	131	1,35± 1,97	46	0,74± 0,34	15	1,18± 0,32
55—64	97	5,02± 1,02	26	4,6± 1,02	10	4,75± 1,02	71	1,21± 0,63	26	0,58 0,18	8	1,13± 0,35

Альфа холестерины дундаж хэмжээ

(Хүснэгт 2)

Судалгааны байршил	Холестерин					
	Улаанбаатар		Дорнот		Өвөрхангай	
Насны бүлэг	M	±	M	±	M	±
45—44	133	1,44±0,32	72	1,61±0,39	10	1,47±0,37
45—54	146	1,40±0,32	45	1,55±0,34	13	1,32±0,40
55—54	93	1,42±0,36	22	1,67±0,35	6	1,35±0,16

УРГАЛ МЭДРЭЛИЙН ТЭЖЭЭХ (СИМПАТИК)  
ТОГТОЛЦОО ДАРАНГУИЛАГДСАН НӨХЦӨЛД  
ХАРХНЫ ЗҮРХНИЙ БУЛЧИНГИЙН БИЧИЛ  
ЭРГЭЛТИЙН ТОРНЫ ТӨГӨЛДӨРЖСӨН ЗАГВАР  
БҮРЭЛДЭХ УИЛ ЯВЦ ТҮҮНИЙ ОНЦЛОГ.

Д. Амгаланбаатар, Б. Дагданбазар  
А.УИС.

Ургал мэдрэлийн симпатик буюу тэжээх тогтолцосны дутмагшилтай хүнд зүрхний бичил эргэлтийн торны төгөлдөржсөн загвар хэрхэн бүрэлддэг болохыг судлах нь зурхний эмгэг жам, эмнэлзүйн талаар дэлхийн анагаах ухаанд

тайлагдаагүй байгаа олон асуудлыг тайлж, эмчилгээ оношлогоог боловсронгуй болгоход нэн ач холбогдолтой юм

Эрүүл биеийн бүтцийн шинжлэх ухаанд ургал мэдрэлийн тэжээх болон хэмнэх (парасимпатик) тогтолцооны илэвхжил хүний цул сав эрхтэний цусны бичил эргэлтийн торны төгөлдөржсөн загвар үүсэхэд хэрхэн нөлөөлдөгийг судалж тогтоосон ажил их цөөн юм.

Тэр тусмаа зүрхний бичил судасны торны төгөлдөржсөн загвар үүсэхэд уг тогтолцоо яаж нөлөөлдөгийг судалсан ажил их ховор юм. Энэ нөхцөлийг харгалзан бид хархны 120 нярай гөлчгийн булчинд адреноблокат-изобариний нь 15 мг-аар бодож 30 хоног тарьж ургал мэдрэлийн хамгаалах тогтолцоог дарангуйлан, зүрхний булчингийн цусны бичил эргэлтийн судсыг цутгалагийн болон цутгалагийн бус арга, цахим бичил дуран авайн аргаар шинжилж үзсэн юм.

### СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгаанаас гарсан бодит баримт, түүнд хийсэн дун шинжилгээт бид төрсний дараах нэг сар, 2—3 сар, 4—5 сар гэж гурав ангилан авч үзлээ:

Төрсний дараах нэг сар. Ургал мэдрэлийн тогтолцоо нь дарангуйлагдсан чэг сартай хархны гөлчгийн зүрхний булчин доторхи артериол ижил насны эруул хархныхыг бодвол илт өргөн, түүний салаа нь  $38,880 \pm 2,832$  мкм, зүрхний булчингийн нэгдүгээр зэрэглэлийн багцны голоор булчингийн ширхэгийн дагуу байрлаж мод лугаа нарийхан олон артериол болиж самбарлаж байна. Энэ мөчөөс эхлэн дээрх артерийг бид булчингийн тэнхлэгийн артер гэж нэрших болно.

Зүрхний бичил эргэлтийн торны эхлэл болох артериолууд энэ насанд харьцаангуй өргөн хана цүлхэнтэй болж, байрлал нь өөрчлөгдөж байгааг тогтоолоо. Артерийн хялгасан судастай холбодог хувиарлах артериолууд харьцаангуй урт харагдаж байна. Энэ нь ургал мэдрэлийн тэжээх тогтолцоог дарангуйлах явцад илэрч байгаа зүрхний булчингийн томролын үед булчингийн багшиы уrtsах үзэгдэл явагдаж буйг илтгэж байж болох юм. Түүнчлэн энэ судас артериолсо бодвол хана нь маш их цүлхэнтэй, зарим бичил судасны торны бэлдмэл дээр энэ судаснууд эрих шиг харагдах нь цөөнгүй ажиглагдлаа. Энэ нь артериолын ханы голтер булчингийн мэдрэлжүүлэлт алдагдаж хэсгийн чанартай судасны саажил илэрч байгааг харуулж байж болох юм. Бичил эргэлтийн судасны торны эс, эдэд цус авчрах хэсгийн бүх судасны голч нь жигд биш, салаалах

хэв маяг эрүүл хархныхаас эрс өөр байгаа нь ажиглагдлаа. Зарим талбайд артериолууд булчингийн ширэгээ дагаж ямар ч салаа өгөлгүй явааар үзүүрлүүгээ багц салаа өгч хялгасан судсанда шилжиж байх юм. Зарим тохиолдолд хялгасан судасны жижиг тогтоонобс бүрэлдээн торны дэвсгэртэй эмх цэги муутай олон тор үүсгэх нь бас ч цөөнгүй байна. Энэ тохиолдолд зүрхний булчинг шинжлэхэд судасны завсар нь илт тод, нүдээр харахад хөвсгөрдүү, бичил бэлдмэл бэлдэж дуран авайгаар шинжлэхэд судасны давсар нь илт тодорсон зурхний булчингийн эсийн шингэн хоссовч ихтэй болсон харагдаж байна.

Бичил эргэлтийн торны артерийн хэсэг түүний торны байдлыг зурхний булчингийн нь байдалтай хамтад нь авч үзээд щугнэхэд ургал мэдрэлийн хамгаалах тогтолцоог дарангуйлсны дараах нэг сард зурхний булчингийн томрол, нэгэн шинжтэй өөрчлөлттэй хавсарч явагддаг, бичил эргэлтийн торны артерийн хэсгийн судасны эрэмбэжих үзэглэл хэвийн үед шусаар хангаж буй зуравсныхаа бодисын сомилцооны эрчимээр тодорхойлопддог зүй тогтол алдагдаж, цус зурхний булчинд тархдаг юм гэсэн төсөөлөл билэнд төрсөн.

Цахим дуран авайч шинжилгээнд материал авч судалж үзэхэд нэг настай эрүүл хархны зурхний булчингийн ижил нэртэй судастай ерөнхийдөө төстэй боловч артериолын хархны гөлгөр булчингийн эсүүл нимгэвтэр, митохондр нь хөөж хөндий нь тодорсон, Т—сувган тогтолцооны гүүрснүүд эндоплазмын торны туламнууд илт өргөссөн байна. Суурин мембрэн дотор хөхөлжийн эсийн талаасаа зарим хэсэгт хөвсийсөн, тараах артериолын хянанд гөлгөр булчингийн эс дотор зарим газраа нийлсэн байх нь олонтоо ажиглагдлаа.

Бичил эргэлтийн торны артерийн хэсгийн судасны өөрчлөлт хялгасан судасны торны дур төрхэнд зохих ёсоор нөлөөлсөн байлаа.

Ургал мэдрэлийн тэжээх тогтолцоо нь дарангуйлалгасан нэг сартай хархны зурхийн булчингийн хялгасан судас ижил наасны эрүүл хархныхайтай харьнуулахад илт нарийн ( $0,05 > P > 0,01$ ) зарим газар бигүүртлээ нарийссан байдаг. Энэ байдлаасаа болсод хялгасан судас бас эрих шиг булдуутсан харагдаж байлаа. Үүний зэрэгцээ хялгасан судасны артериал болон венул талын үзүүр бүтэц байрлалын хувьд эрс ялгаатай харагдаж байлаа.

Нэгдүгээрт хялгасан судасны венулын үзүүр илт өргөн эрс тахирласан байна. Ийм өөрчлөлт хялгасан судасыт алгасч венулыг артериолтой холбосон тушаа судас ихтэй

газар илүү тод ажиглагдаж байлаа. Хялгасан судасны торны энэ байдал ургал мэдрэлийн тэжээх тогтолцооны дараангуйлалын нөхцөлд цус хялгасан судасны тороор бус артериол-венулын тушаагаар дөт замаар венийн хэсэг рүү шилжиж, венийн талын үзүүр буцаж цусаар дүүрдэг байж болох юм гэж бид таамаглаж байна. Цахим дуран авайгаар шинжилж үзэхэд хялгасан судасны хөндий нь нарийхан ихэнх тохиолдолд хоссан хана нь эрүүл хархныхтай нэгэн ацил суурийн мембрان дээр суурилсан нэг эгнээ дотор хөхөлжит эсээс бүтсэн байх боловч дотор хөхөлжит эсийн цустай харьцах гадаргууд цусны цагаан эсүүд наалдсан байх юм уу зарим тохиолдолд ханаар нь нэвчин нүүдэллэж байгаа нь олонтоо ажиглагдах юм. Суурийн мембран зарим газар бүтцээ алдаад нүх сув нь томрох юм уу шинээр ч үүсч байгаа бололтой юм. Иймэрхүү өөрчлөлт судасны венийн үзүүрт олонтоо тааралдаж байлаа.

Бичил эргэлтийн торны вентийн хэсгийн судаснуудад мөн толорхой өөрчлөлт байгааг бид олж тогтоолоо. Хялгасан судасны дараах венул мөн наасны эрүүл хархны зүрхтэй харьцуулхад илт өргөн богинохон хана нь бичил ивэрхийтэй юм. Цутгалага хийж илрүүлсэн тохиолдолд цутгасан будагч бодис зарим газар ханаар нь нэвчиж орчны эдэд нь юулэгдсэн байх нь цөөнгүй тааралдлаа. Цуглуулах венуулуудад ч мөн иймэрхүү өөрчлөлт ажиглагдаж байлаа. Үүний зэрэгцээ хялгасан судсыг алгассан судсан тушаа ихтэй, зарим тохиолдолд эдгээр тушааны венийн талын үзүүр нь колбо маягтай өргөссөн байх нь олонтоо ажиглагдлаа.

Цахим дуран авайгаар шинжилж үзэхэд судасны хананд гарсан дээрх өөрчлөлтүүд гэрлийн дуран авайгаар илрүүлсэн тэдгээр судасны өөрчлөлтийг ахин баталсан баримт тодорч байна.

Хялгасан судасны дараах болон цуглуюлах венуудийн голч илт өргөн, цусаар хэт дүүрсэн хөнлөн огтлол дээр зурсан хоёр төрлийч венулын суурийн мембран дээр суурилсан 3—4 лотор хөхөлжит эсээс бүтсэн дүүрэн цустай байх нь сложе байлаа. Цуглуюлах венулын суурийн мембранны гадуур пецифичийн эсүүд түүний сэргэн элбэгтэй болохсөр хялгасан судасны дараах венулаа бодвол хана нь зузаан юм шиг ажиглагдлаа. Мөн наасны эрүүл хархны зурхий хялгасан судасны дараах венул цуглуюлах венулын хана нь иймэрхүү бүтэцтэй харин туршилт тавьсан хархны эдгээр судасны хананд дараах онцлог ажиглагдлаа.

Хялгасан судасны дараах венулын ханыг бүтээхдээ дотор хөхөлжит эсүүд хоорондоо эрмэгээрээ хурэлцэх юмуу зарим газар нэг нь негөөгийнхөө ирмэг дээр үл мэдэг давхарласан маягтай холбогдсон байх нь олонтоо ажиглагдлаа. Цуглуулах венулын хананд дээрх эсүүд холбогдсон хэсэгтээ маш их хуниас үүсгэсэн байх нь тааралдлаа. Үүний зэрэгцээ дээрх хоёр судас ханандаа том нүхтэй тор нь цуглуулах венул руу дөхөх тутам улам том болж цусны улаан эс юм уу ялtsаар, ховорхон тохиолдолд дотор хөхөлжит эсийн тасархайгаар бөглөөстхий байх нь тогтоогдлоо. Иймэрхүү нух мөн хялгасан судасны дараах венулаас цуглуулах венулд шилжих туламнуудын ханан дээр мөн их тааралдаж байлаа. Тэгэхдээ ихэвчлэн түүний ханыг бүтээж байгаа дотор хөхөлжит эсүүлийн ирмэгүүдийн нийлэл шүргэцэлийн ойролцоо тохиолдож байлаа. Дотор хөхөлжит эсийн гадаргуу цоорхой үүссэн зарим хэсэгтээ атираатсан байх нь олон ажиглагдлаа. Дээрх үзэгдлийг дагалдаад хялгасан судас венулуудын цустай харьцах галаргуны өөрчлөлт ихтэй болж байгаа нь мөн ажиглагдлаа. Тэр тусмаа хялгасан судасны дараах венулд ийм өөрчлөлт бур хүчтэй илэрч байлаа. Бичил салбан, цэлмэн, гүнзгий цүлхэн ч тааралдаж байлаа. Зарим талбайд дотор хөхөлжит эсийн цитоплазмын тасархай плазмоцитоз хагалгаж байлаа.

Дотср хөхөлжит эсийн дотоо гадаргуугийн өөрчлөлтийг дагалдаад цусны урсаах чанарын өөрчлөлтийг илэрхийлсэн бутцийн өөрчлөлт мөн ажиглагдаж байна. Ханын өөрчлелт ихтэй судсанд дээр дурьдсан өөрчлөлт бүхий хананд нааллах эсвэл цусны ялтас эсийн бөөгнөрөлүүд дотор хөхөлжит эстэй наалдсан байх нь их ажиглагдлаа. Цусны урсаах чанарын өөрчлөлт ихтэй газар дотор хөхөлжит эсийн гадаргуугийн тогтоц харьцангуй голигор болж харагдах юм.

Цусны хялгасан судас венулуудын ханын өөрчлөлт цусны урсаах чанарын өөрчлөлтийг харьцуулж бясалгаж сухад ДВС хам шинжийн уед бичил эргэлтийн тонрын хэт чанд бутиэнт мөн иймэрхүү өөрчлөлт гардаг болов уу гэсэн сэтгэгдэл төрж байлаа.

Доторхөхөлжит эсийн гадаргуугийн өөрчлөлтийн зээрэг нь бичил эргэлтийн судасны ханын эсчүүдийн туслах эрхтэний хэт чанд бутцийн өөрчлөлттэй шууд хамааралтай байлаа. Харьшуулаад үзвэл бичил эргэлтийн тонры артерийн хэсгийн дотор хөхөлжит эс болон гөлгөр булчингийн эсэд эсийн туслах эрхтэний өөрчлөлт харьцангуй бага нэг, хоёрхон туслах эрхтэнийг хамарсан байх нь ажиглагдлаа. Бүх бичил судасны дотор хөхөлжит эсийн митохондри томорч доторхи хамрууд нь хана руугаа шахагдан хоорондох зайд

нь өргөсгөсөн. Зарим митохондри дотроо хамаргүй хөвсгөр утастай цэврүү болж хувирсан байх нь цөөнгүй байлаа. Ялтаст иж бүрдэл болон эндоплазмын торлог бас нилээд өөрчлөгдж байна. Эдгээр туслах эрхтэний суваг цэврүүнүүд илт өргөссөн эсийн шингэний нилээд хэсгийн иймэрхүү өөрчлөлт туслах эрхтэнүүд эзэлж байна.

Бенуулуудын хананд байрлалдаг перицитийн эсүүдэл дээр дурьсан эсийн туслах эрхтэний өөрчлөлт мэр сэр ажиглагдаж байлаа. Дотор хөхөлжит эс перицитийн эсийн сэр тэнгийн хоорондох зайд өргөсч перицитийн эсүүдийн сэргээн гүүдийн хоорондох холбоос ховорхон таафалдах болсноос үндэслээд урвал мэдрэлийн тэжээх тогтолцоо дараангуйлсан нэхцөлд перицитийн эс судасныхаа хананаас хөндийрдэг гэсэн дүгнэлтэнд хүрч байна. Энэ нь судасны ханын өөрчлөлттэй холбоотой судасны эргэн тойрон хаван уучуу байгаатай ч холбоотой байж болох юм.

Төрсний дараах хоёроос-гурван сар Туршилтын дараах хоёр сараас зүрхний булчингийн багцын тэнхлэг arteri (38,22+2,4 мкм) татагдаж ялигүй тахиралдсан түүнээс эх авч байгаа arteriol, хувиарлах arteriol илт өргөссөн ( $0,01 < P < 0,05$ ) тор нь нилээд өөрчлөлттэй болсныг ажиглалаа.

Өмнөх наасны амьтадтай харьцуулахад arteriol булчингийн багцын харьцаа алдагдсан. Эдгээр судасны нуман эргэлтэнд цунхийт илрэч голч нь илт ихэссэн байна.

Бичил эргэлтийн зарим arterийн хэсэгт гарсан өөрчлөлт хялгасан судасны торонд зохих хэмжээгээр нөлөөлж байгаа нь харагдаж байлаа. Өмнөх сарынхтай харьцуулахад хялгасан судас илт өргөссөн ( $0,05 > P > 0,01$ ) зарим тохиолдолд бичил ивэрхий үүстлээ өргөссөн, хялгасан судасны торны ерөнхий тогтоцыг харахад нэгэн жигд өргөн, тэжээх болон гол хялгасан судсууд голчоороо өөр хоорондоо ялгарахгүй. Хялгасан судасны тогтолцоонууд бие гүйцсэн хархных шиг хэлбэр хэмжээнд хүрсэн авч зруул үел зурхний булчингийн үе, давхаргуудад ажиглагддаг онцлог төдийлөн тодрохгүй байна. Өмнөх туршилтын амьтадад хялгасан судсыг алгассан тушаагаар эргэх цусны бичил эргэлт нийтэд онцлог байсан бол эдгээр амьтадад хялгасан судасны төр цусны эргэлтэнд тархмал байдлааар оролысон дур зураг талбай бүхэнд гжиглагдаж байна.

Цахим дуран авайгаар шинжилж үзэхэд arteriol, хялгасан судасны хана өмнөх туршилтын амьтадтай ижил төсстэй бутэцтэй байлаа. Ялгаа нь гэвэл хялгасан судасны ханын дотор хөхөлжит эсүүдийн бөөм бусэж хөөсөн, томорсон бөөм орчмын зайд нь өргөссөн, дотор хөхөлжит эсийн захын

зурvas нүх цонх ихтэй, суурийн мембрран холбоо бүхий микропиноцитозын цэврүү ихтэй болсон байна. Энэ бүхэн судаснаас эд рүү нэвчилт ихсэж буй бодит баримт юм. Митохондрийн тоо цөөрөхийн хирээр цэврүү маягийн аварга митохондри олширч байна. Хялгасан судас венийн талруугаа өргөсч хооронд нь олон тооны холбоо үүсгэн хялгасан судасны дараах нэгдүгээр зэрэглэлийн венулыг үүсгээд тэр нь дөрөв таваараа холбогдон уутанцар үүсгэж байна. Энэ уутанцарын хэлбэр их олон янз байна. Өмнөх наасны хархтай харьцуулахад эдгээр уутанцарын хэмжээ ихэссэн тоо нь ч илт олон болж харагдах юм. Зарим харах талбайд хялгасан судасны нь торыг харагад бэрхтэй тийм олон тулагман судас харагдаж байлаа.

Бичил эргэлтийн торны венийн хэсгийн тогтоцын өөрчлөлт судасны ханын бүтцэнд зохих хэмжээгээр нөлөөлсөнийг бид дуран авайн шинжилгээгээр харж тогтоолоо. Гэрлийн дуран авайн шинжилгээнд хялгасан судасны дараах венул болон цуглуулах венулын дотор хөхөлжит эсийн бөөм мөн наасны эрүүл хархны судастай харьцуулахад илэрхий дугариг харагдаж байна. Энэ нь дээрх судасны голч туршилтын амьтдад эрс ихэсч дотор хөхөлжит эсүүд өргөөшөө их татагдаж байгаагийн баримт байж болох юм. Энэ өөрчлөлтийг дагаад цахим дуран авайн шинжилгээнд нилээд өөрчлөлт гарлаа. Дотор хөхөлжит эсийн шингэн дэх эсийн яс мод болох бичил гуурснуудын бүтэц байрлал нилээд өөрчлөгдсөн байлаа. Дээрх гуурснууд томроод дотор хөхөлжит эсийн бусад эстэйгээ холбоо бүхий хэсэгт ойр, эсийн зах руу зонхилюн байрлах аястай байна. Энэ нь уул дотор хөхөлжит эсийн холбоог бэхжүүлж хэлбэр бусад эстэйгээ харьцах орон зайн харьцаа нь хадгалахад чиглэсэн дасан зохицох шинж бүхий урвал гэлтэй юм. Дотор хөхөлжит эсийн туслах эрхтэнүүдэд ажиглагдаж байсан өөрчлөлтийд улам гүнзгийрсэн байдалтай харагдаж байна. Бараг бүх митохондрууд хамарласан тасалгаа нь байхгүй дотроо хөвөн утас шиг бүтэцтэй электрон нягт шингэнээр дүүрсэн цэврүү болж хувирсан байна. Зарим цэврүүтсэн митохондри судасныхаа хөндий рүү юмуу судас орчмын эд рүү хагарч доторхи шингэн нь гоожсон нь цөөнгүй ажиглагдлаа.

Өмнөх наасны туршилтын харханд тэмдэглэсэн цусны бүлэгнэлийн өөрчлөлт нилээд гүнзгийрч хялгасан судасны дараах венул, цуглуулах венулын хананд байгаа нух цонхиы хэмжээ илт ихэсч түүний ойролцоо цусны эсүүд бөөтнөрсөн зарим тохиолдолд томооюс том бөөгнөрөл үүсгэж судасныхаа ханын ерөнхий байдлыг өөрчилсөн нь ажиглагдлаа.

Зарим тохиолдолд судасны ханын суурийн мембрани бүтэц хэсэг газар алдагдаж цоорхой үүссэн янтай ажиглагдах юм.

Төрсний дараах 4—5 сар Бичил тор түүний нарийн судасны хананд гарсан өөрчлөлтүүд илт гүнзгийрэн зүрхний булчинд холбогч эдээр солигдсон судастай цэгүүд харах талбайд цөөнгүй ажиглагдаж байна. Хялгасан судасны голгоо сунаж хэлбэрийг нь тодорхойлж хэлэхэд бэрх голгоо бухий хялгасан судасны торгой хэсгүүд илэрч хугацаа хойшлох тутам ихсэх аястай байна.

Бид симатик мэдрэлийг нь дарангуйлсан хархан дээр хийсэн туршилтан дээрээ үндэслэн симпатик мэдрэл дарангуйлалгасан нөхцөлд зүрхний булчингийн тодорхой хэсгийн эс эдийн бадисын солилцооны төлөв байдалд тохирсон тийм бичил эргэлтийн тор үүсэх боломжгүй гэсэн дүгнэлтэнд хүрлээ. Харин эдгээр амьтдад энэ үйл явц өвөрмөц хувилбараар хэрэгжиж байгааг тогтоолоо.

Бидний судалж тогтоосноор эдгээр амьтдад зүрхний булчингийн бичил эргэлтийн торны төгөлдөржсөн загвар дараах шатаар дамжин бүрэлдж байна.

1. Төрөл бүрийн судсан тушаагаар цус дөтлөн эргэх урвал давамгайлах үе—энэ үед бичил эргэлтийн торны тодорхой сан цусаар ядуурч, артериол, болон хялгасан судасны голч илт нарийсч хялгасан судасны дараах болон цуглуулах венул тэдгээрийн тулам илт өргөссөн дүр зураг ажиглагдана.

Цахим дуран авайн шинжилгээнд хялгасан судас төрөл бүрийн венулуудын ханын дотор хөхөлжит эсийн цустай харьцах гадаргуугийн наалдуулах чанар ихэсч цусны дурст зэлментүүд түүнд наалдаж бөөгнөрөл үүсгэн дээрх судасны хана цонхорсон байгаа нь ажиглагдлаа. Бүх эсүүдэд тэдгээрийн митохондри дотор тасалгааны хамрын хэвийн тогтоц өөрчлөгдж цэврүүших үзэгдэл гарч байна. Энэ нь Төрсний дараах буюу туршилтын дараах 1—2 сард булчингийн бичил эргэлтэнд ажиглагдлаа.

2. Дасан зохицох урвалын үе—энэ үед бичил эргэлтийн торны сан цусаар дүүрч ихэнх бичил судасны голч өргөсч эс эдийг бололцооны хэрээр цусаар хангах тархмал урвал газар авсан дүр зураг ажиглагдлаа. Цахим дуран авайн түвшинд хялгасан судас болон түүний дараах судас цуглуулах венулын ханын дотор хөхөлжит эс болон пептидийн эсэд ларсан бүтцийн өөрчлөлт гүнзгийрч дээрх эсүүдийн митохондрийн ихэнх нь цэврүү болон хувирч суурийн мембранд бүтцийн өөрчлөлт тархмал байдлаар илэрч бичил судасны хана цонхорсон байгаа нь ажиглагдлаа.

Үүний зэрэгцээгээр бичил судасны бүтцийн өөрчлөлт бүхий хананы ойролцоо судасны доторхи цусны дүрст элементүүд бөөгнөрч цусны дүрст бүлэгнэл ихсэх үзэгдэл ажиглагдаж байна. Туршилтын дараах 2—3 сард ажиглагдлаа.

3. Дасан зохицох урвал алдрах буюу бичил судас эрт стлөх үе—энэ үед бүх бичил судас нарийч хялгасан судасны торны орон зайн бүтэц алдагдсан байдал ажиглагдлаа. Энэ өөрчлөлтийг дагалдаад срчны нь булчингийн эдэд бүтцийн өөрчлөлт сорвижих үзэгдэл илрэлээ.

Цахим дуран авайн шинжилгээнд бичил судасны хананд өмнөх шатанд ажиглагдсан өөрчлөлтүүд судасны ханын нэвт өөрчлөлт болтлоо гүнзгийрсэн байгаа нь ажиглагдлаа. Энэ үе туршилтаас хойших 4—5 сараас эхэлж байна.

### ТАРХМАЛ ХОРДЛОГОТ БАХЛУУРТАСЫН ҮЕД БАМБАЙ БУЛЧИРХАИН ИОД ШИНГЭЭХ ЧАДВАР БОЛОН ЦУСАН ДАХЬ ДААВРУУДЫН ӨӨРЧЛӨЛТ

#### Ц. Лхагвасүрэн дэд эрдэмтэн АУИС

Бидний хэрэглэж буй хүнс тэжээлнийн зүйлүүдэд агууллагдах бичил элементүүд, ялангуяа иодын хэмжээ дутагдах нь бамбай булчирхайн (ББ) хэвийн үйл ажиллагааг эмгэг байдалд хүргэдэг томоохон хүчин зүйл болдог.

Манайд дотоод шүүрлийн булчирхайн төрөл бүрийн өвчнүүдээс ББ-н эмгэгүүд зонхиолдож байгаат дээрх шалтгаануудтай холбон узэх бүрэн үндэслэлтэй.

Бид УКТЭ-ийн дотоод шүүрлийн булчирхайн өвчнийг эмчлэх тасагт хэмтэж эмчлүүлсэн хүмүүсийг судалж үзэхэд 25 орчим хувь нь ББ-н ямар нэг өвчтэй хүмүүс байв. ББ-н ямар нэг өвчтэй хүмүүсийн ихэнх нь буюу 78% нь тархмал хордлогот бахлууртас (TXB), 10,5% нь зангилаат бахлууртас, 5,1% нь хавсарсан хэлбэрийн бахлууртас, 2,7% нь ББ-н үйл ажиллагааны дутагдалтай өвчтөнүүд байсан юм. Хамгийн түгээмэл тохиолдож байгаа TXB-аар ихэвчлэн 20—40 наасны эмэгтэйчүүд өвчилж байна. Эдгээр өвчнүүд нь үндсэндээ ББ-н үрэвсэлт өвчнүүд мөн боловч дархлалын механизмыг хэр сэдээж байгаагаараа харилсан адилгүй. Дархлалын өвөрмөц урвалын эрчим, бамбай булчирхайн эд эсүүд гэмтэж байгаа зэрэгээс хамаарч даавар нийлэгжүүлэх болон ялгаруулах явц нь өөрчлөгддөг. Энэхүү өөрчлөлтүүдийг шусанд тироксин ( $T_4$ ), трийодтиреонин ( $T_3$ ), тиреотропин (TTg) зэрэг даавруудын хэмжээ, ББ-н иод шингээх чадвар хэрхэн өөрчлөгддэж байгаа зэргийг радиоизотопийн аргаар судалж үзлээ.

Л. Д. Линденбратен, Ф. М. Лесс нар эрүүл хүмүүст ББ-н йод шингээх хэмжээг 2, 6, 12, 48 цагуудын завсарлагаатайгаар узэж 9—10%, 17—19%, 29—32%, 27—29% байсныг тогтоосон бөгөөд эрүүл монгол хүмүүст мөн цагуудын завсарлагаатайгаар судалж узэхэд (Ц. Лхагвасурэн, Н. Оюун, П. Онхуудай) дунджаар 13, 9%, 22,9% 30,7%, 29,2% байлаа. Европын хүмүүст судлаачдын тогтоосон хэмжээтэй харьцуулж узэхэд монгол хүмүүсийн ББ-н йод шингээх хэмжээ нь сорилт эхэлснээс хойших 2—6 цагийн дараа арай илүү, 12—48 цагийн дараах шингээлт нь үндсэндээ ойролцоо байлаа. (I хүснэгтээс үз) Гэтэл ТХБ-тай хүмүүст мөн цагуудын завсарлагаатайгаар судалж узэхэд насын ангилал бүрт өвөрмөц хэлбэлзлэл гарч байгаа нь ажиглалдсан бөгөөд дунджаар 43,48%, 55,54%, 60,10%, 55,08% хүртэл нэмэгдэж байгаа нь (II хүснэгтээс үз) ТХБ-тай өвчтөний ББ-д йодын хэрэгцээ ихсэж байгаат харуулж байна. Нэг ёсондоо дааврыг эрчимтэй нийлэгжүүлэх шаардлагаас, эсвэл дааврын зохистой хэмжээг хангаж чадахгүйгээсээ болоод ББ нь йодыг хэвийн хэмжээнээс илүү ихээр авч байна гэж узэж болох юм. Даавруудын хэмжээ ТХБ-тай хүмүүсийн цусанд хэрхэн өөрчлөгдэж байгааг судалж узэхийн өмнө эрүүл хүмүүст байгаа хэвийн хэмжээг нь тодорхойлох шаардлага зүй ёсоор гарсаны дагуу эрүүл гэж магадласан 78 хүний цусанд шинжилгээ хийж үзэв.

Насанд хүрсэн монгол хүний цусан дахь тиреотропин  $1,07 \pm 0,5$  МЕ/1, тирокоин  $60,69 \pm 7,61$ , трийодтиреонин  $2,16 \pm 0,3/1$  байгаа нь Ф. М. Лясс, Е. Г. Настикова зэрэг судлаачдын тогтоосон болон олон улсын I РАС зөвлөлөөс гарсан хэвийн хэмжээний үзүүлэлтүүдээс доогуур, ялангуяа  $T_4$  нь нилээд бага байгааг тогтоолоо. (III хүснэгтээс үз) Харин ТХБ-тай өвчтөний цусанд дээрх дааврууд эрүүл хүмүүсийнхээс мэдэгдэхүйц ихээр нэмэгдэж  $T_4$  нь  $153,48 \pm 29,1$  (1),  $T_3$  нь  $3,02 \pm 0,9$  болтлоо өсчээ. Харин ТТГ нь  $1,15 \pm 0,28$  буюу дээрх хоёр даавартай харьцуулахад ялимагүй бага хэлбэлзэлтэй байна. (4-р хүснэгтээс үз) Ийнхүү  $T_4$ ,  $T_3$  дааврууд ТХБ-ын уед нэмэгдэж байгаа нь ББ-н үйл ажиллагаа ихэссэнийг харуулж байгаагийн зэрэгцээ түүний нөлөөгээр эрхтэн тогтолцооны үйл ажиллагаа өөрчлөгддэх хордлогын шинж тэмдэгүүд илрэхийн уг сурвалж нь болно. Энд Тиреотропин дааврын хэмжээ төдийлэн их нэмэгдэхгүй байгааг мэдрэл шингээний зохицуулалтын харши мэдээллийн замаар зохицуулагдаж байна хэмээн тайлбарлаж болно. Чухам иймээс ТХБ-ын уед ББ-н үйл ажиллагааг голлон сэдээгч нь ТТГ биш, харин ЛАТС хүчин зүйл боло-

ББ-н эсээс ууссан өөрийн зэрэгтөрөгчүүд мен болохыг харуулж байгаа юм.

Хийгдсэн судалгаамаас дүгнэж хэлэхэд:

— ББ-н йод шингээж авах чадвар энэхүү эмгэгийн эхэн үед илүүтэй байгааг үндэслэн бидний хэрэглэж байгаа хүнс тэжээл дэх йодын хэмжээс бага байна гэж үзэх үндэслэлтэй, Цаашид хосл хүнсний зүйлүүдэд байгаа йодын хэмжээг нарийн судлан тогтоож, улмаар бамбай булчирхайн эмгэгээс сэргийлэх үр дүнтэй арга хэмжээг авах нь зүйтэй байна.

— ТТГ, Т<sub>4</sub>, Т<sub>3</sub> болон бамбайн йод шингээх байдлыг эрүүл монгол хүмүүст судлан тогтоосон нь эмгэг явцыг баримтлах бодитой хэмжүүр болох практикийн ач холбогдолтой юм.

— ТХБ-тай хумууст ББ-н йод шингээх хэмжээ 2, 6, 24, 48 цагуудад эрс нэмэгдэж байгаа болон Т<sub>4</sub> мөн Т<sub>3</sub> дааврын хэмжээ ихэсч байгааг тогтоосон нь онцлогогооны болон эмчилгээний үр дүнг хянан үзэх бодитой хэмжүүр болох байна.

ТТГ дааврын нэмүү сэдээлтээр ББ-н үйт ажиллагаа идэвхжин улмаар хэвийн нөхцөлд цусанд байдаггүй тиреоглобулин зэрэг ББ-н гаралтай эсрэг төрлүүд цусгчд, нэвчин өөрийн зэрэг биесийг уусгэж байна гэж үзээд ийм тохиолдолд ЛАТС болон ББ-т сэдээгч иммуноглобулинууд уг булчирхайг сэдээнсээр ТХБ-ыг уусгэж байна гэсэн урьччилсан таамаглал дүгнэлтэнд хүрч байгаа юм. Ерөөсөө ч ТХБ-ыг аутоиммунный өвчин гэж үздэг шүү дээ.

ТХБ-тай өвчтөнд дээрх үзүүлэлтүүдийг тодорхойлох нь онцлогогооны ач холбогдолтойн зэрэгшээ шаардлагатай үед иммунологийн шинжилгээ хийж үзэх нь эмчилгээний зөв чиг баримжаат тогтооход ихээхэн ач холбогдолтой юм.

(I хүснэгт)

ББ-н иод шингээж авах хэмжээг судлаачдын судалгаатай харьцуулсан байдал

Судлаачид	Судалгаанд хамрагдсан хү- мүүс	ББ-н йод шингээлт (цагаар)			
		2	6	24	48
А. Х. Мироход- жаев	Эрүүл хүмүүст	14	18	30	29
Л. Д. Линден- братен	ББ-н үйл ажил- лагаа буурсан Хордлогот бахлуур	3,3	3,8	5,1	—
Ф. М. Лиасс	Эрүүл хүмүүст	9—10	17—19	29—32	27—29
Н. Оюун Ц. Лхагвасүрэн	Эрүүл хүмүүст	13,9	22,9	30,7	29,2
П. Онхуудай	БТГ-тай хү- мүүст	43,4	55,5	61,7	55,0

(III хүснэгт)

Эрүүл хүмүүсийн цусан дахь ТТГ, Т4, Т3 даавруудын хэмжээг харьцуулан судалсан нь.

Дааврууд судлаачид	ТТГ (ME/l)	T4 (Н мол/л)	T3 (н. мол/л)
Настюкова Е. Г. (ЗХУ)	1,9±0,3	110,5±8,7	2,2±0,1
Ц. Лхагвасүрэн			
Н. Оюун	1,07±0,5	60,69±7,6	2,16±0,3
П. Онхуудай			
Олон улсын Г PAC зөвлөл	1,8—2,2	72—123	2,30

II XYCHET

ГХБ-тай өвчтөний бамбай бүлчирхайн йод шингэх хэмжээг насны энгилэлээр тодорхойлсон судалгаа

## ( IV хүчинэгт )

ТХБ., тай өвчтөний цусанд ТГ, Т4, Т3 даавруудын хэмжэг  
насны ангилааар тодорхойлсон судалгаа

Насны ангилаам	Судалгаанд хамрагдсан хүний тоо	ТГ (ME/l)	T <sub>4</sub> (Н. мол/л)	T <sub>3</sub> (Н. мол/л)
19 хүртэл	11	1,20±0,351	134,09±29,2	3,570±0,81
20—29	30	1,11±0,221	149,50±24,8	2,596±1,20
30—39	34	1,07±0,207	178,53±45,2	3,052±1,20
40—49	14	1,21±0,319	162,43±33,4	3,393±0,97
50-с дээш	9	1,14±0,302	142,89±12,7	2,489±0,56
Дүндэж хэмжээ	98	1,15±0,280	153,48±29,1	3,20±0,95

## ТОДОРХОЙ ХҮН АМЫН ДУНД ТАРХИНЫ СУДАСНЫ ӨВЧНИЙГ НӨХЦӨЛДҮҮЛЭГЧ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ТАРХАЛТЫН АСУУДАЛД

Эрдэм шинжилгээний  
төргүүлэх ажилтан, дэд  
эрдэмтэн Д. Баасанжав  
Эрдэм шинжилгээний  
ажилтан Г. Долгор

Тархины судасны өвчин тухайлбал тархинд цус харвах,  
цус тасалдах, цусан хангамжийн архаг дутаатлын хожуу  
хэлбэрүүдийн эмчилгээний үр дүн төдийлөн хангалтгуй,  
тэдгээрийн улмаас нас барах, тахир дутуу болох нь өндөр  
үзүүлэлттэй хэвээр байна.

Тархины судасны өвчний (ТСӨ) урьзчилан сэргийлэх  
идэвхтэй арга хэмжээг хүн амын дунд явуулж, хүндэрэлийг  
саатуулан өвчлөл, нас баралтыг бууруулах бүрэн боломж-  
той байгааг манай орны болон гадаадын судлаачдын су-  
далгаа нотлож байна.

Бид тодорхой хүн амын дунд ТСӨ-ний нөхцөлдүүлэгч  
хүчин зүйлийг илрүүлэн тогтоох зорилт бүхий судалгааг  
1982—1984 онуудад явуулав.

### Судалгааны арга ажлын жэмжээ

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас боловсруулсан «Хүн амын дунд ТСӨ-ний НХЗ-ийг илрүүлэн т отдох» аргачлал, асуун лавлах картаар судалгаа хийв. Судалгасид Анагаах ухааны хүрээлэнгийн дотор өвчин судлалын сектор, биохимийн лабораторийн эрдэм шинжилгээний ажилтан, мэргэжилтийн, зүрх судасны өвчинг оношилох, тэтгээрийн үе шатыг тогтоох, лишидийн солилцол тодорхой-  
лох шинжилгээнүүдийг хийх чиглэлээр хамтран оролцлов.

Тодорхой хүн амын дунд ТСӨ-ний НХЗ-ийг илрүүлэх тогтоохдоо ахуйн дадал зуршыл, амьдралын тогтоосон хэв маяг, нийгмийн болон үйлдвэрийн нөхцөл, удамшлын байдал, бие махболийн үйл ажиллагааны дотоод дахь өөрилөлт, зарим нэг өвчин зэрэг ТСӨ-ийг уусгэн хөгжүүлэх нөлөө бүхий байж болохоор 20 гаруй нэр төрлийн хүчин зүйлийг тархины судасны «өвчин» илэрсэн ба «эрүүл» гэсэн 2 бүлэгт судалж үзүүлэлтүүдийг харьцуулан дүгнэх аргыг хэрэглэв.

Судалгааг Ажилчин дүүргийн (хуучин нэрээр) хөнгөн үйлдвэрийн 35—64 наасны 3100 (эрэггэй 1609, эмэгтэй 1491) ажилчин, албан хаагчдын дунд явуулав.

## Судалгааны дүн:

Хүн амын дунд явуулсан судалгааны дүнд 10 гаруй төрлийн тархины судасны өвчний НХЗ-ийг илрүүлэн тогтоолоо. Үүнд: тамхи татдаг 33,0%, биеийн жин хэтэрсэн 21,7%, архи уудаг 21,5%, удамшилын сурвалжтай (зөвхөн эцэг эхийн) 17,3%, артерийн даралт ихэссэн 19,9%, биеийн хөдөлгөөн идэвхгүй (гиподинами) 18,0% эмэгтэйчүүдийн дунд 8 ба түүнээс дээш жирэмсэлсэн 28,3% цусан дахь холестерины хэмжээ ихэссэн 6,2%, эзлжийн ажилтай 19,5% зөвхөн шенийн эзлжийн ажилтай 1,8%, цайг давстай уудаг 84,0% тус тус тохиолдолтой байна. (Хүснэгт №1).

Тамхичдын нэг өдөрт дунджаар татах тамхины тоогоор авч үзэхэд өдөрт 10 ш хүртэл тамхи татдаг тохиолдлын үзүүлэлт «өвчтэй», «эрүүл» хоёр бүлэгт (25,8%; 21,9% үнэн магадтай ялгаагүй байна. Харин 11—20 ш хүртэл татдаг тамхичдынх дээрх 2 Бүлэгт 13,4%, 8,1% ( $P<0,001$ ), 21 ба түүнээс дээш ширхэг тамхи татдаг 1,9%; 0,7% ( $P<0,001$ ) тус тус тохиолдлын үзүүлэлттэй байна.

Тамхи татсан хугацаагаар 11—30 жил тамхи тасралтгүй татсан хүмүүсийн тохиолдол «эрүүл» бүлэгт 18,7%, «өвчтэй» бүлэгт 23,4%, ( $P<0,01$ ), 31 ба түүнээс дээш жил татсан 2,7%; 11,7% ( $<0,001$ ) өвчтэй бүлэгт тохиолдлын үзүүлэлт илүү байна. Тамхичдын өдөрт татах тамхини хэмжээ, татсан хугацаа ТСӨ-ний НХЗ болоход шууд хамааралтай байна.

Архи уудаг хүмүүсийг «хааяя», «байнга» уудаг гэсэн 2 тохиолдлыг судалгааны «эрүүл», «өвчтэй» бүлэгт харьцуулахад хааяя хэрэглэдэг тохиолдлын үзүүлэлт ялгаа багатай байхад, байнга хэрэглэдэг тохиолдлын үзүүлэлт «өвчтэй» бүлэгт 2 дахин илүү байна. Үүнээс үзэхэд архийг хааяа уудаг зуршил ТСӨ-нийг үүсгэхэд нөлөөтэй бус, байнга хэрэглэх нь НХЗ болж байна.

Тархины судасны өвчний удамшилын сурвалжийт зөвхөн эцэг эхийн өвчлөлөөр судлахад 2 бүлэгт 39,5%; 11,2%, буюу «өвчтэй» бүлэгт 3 дахин илүү тохиолдолтой байна. Артерийн даралт ихсэх, тархинд цус харвах, цус тасалдах өвчини удамшилын сурвалжаар зонхилох байрыг эзэлж байна.

Биеийн хөдөлгөөний идэвхт байдлаар судалгааг явуулахдаа эрхэлсэн ажлын байдал (суугаа, зогсоо, явж хийдэг, холимог), хувь хүний биеийн тамираар хичээллээгээ эсэхийг харгалзан үзсэн. Үүнд; Биеийн тамираар тогтмол хичээллэдэг хүмүүсийн тохиолдлын үзүүлэлт ТСӨ-тэ:й бүлэгт 17,7%, эрүүл бүлэгт 22,1% ( $P<0,01$ ), биеийн хүчиний

хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийн тохиолдол эрүүл бүлэгт 34,3% ( $P<0,01$ ) өвчтэй булэгт 23,5% байгаа нь ТСӨ-нийг саатуулач хүчин зүйл болж байна.

Биеийн жин хэтэрсэн буюу таргалалтыг жин өндрийн индекс Кетле-ээр тодорхойлсаноор 26—29 хүртэл индекс ихэссэн тохиолдолд эрүүл бүлэгт 13,4%, өвчтэй бүлэгт 23,8% ( $P<0,01$ ) 30 ба түүнээс дээш ихэссэн тохиолдолд өвчтэй бүлэгт 2 дахин илүү тохиолдолтой байна.

Цусанд холестерины хэмжээ 5,18—6,48 ммол/л байгаа тохиолдол тархины судасны «өвчтэй» бүлэгт 10,0%, «эрүүл» бүлэгт 5,1% ( $P<0,01$ ) 6,49—7,76 ммол/л болж ихэссэн тохиолдол дээрх 2 бүлэгт 6,5%; 1,8 ( $P<0,001$ ) 7,77 ммол/л ээс дээш тохиолдолд 7,0; 2,5% ( $P<0,001$ ) өвчтэй бүлэгт тохиолдлын үзүүлэлт их байна.

Бие махбодийн дотоод үйл ажиллагааны өөрчлөлтөөс уламжлан биеийн жин хэтэрсэн, цусанд холестерины хэмжээ ихэссэн өөрчлөлтуудийг бүлэглэсэн тоо хэмжээнээс шууд хамаарахгүйгээр аль ч тохиолдлуудад тэдгээр нь тархины судасны өвчний НХЗ болж байна.

Жирэмслэлтийг 1—2; 3—4; 5—7; 8 ба түүнээс дээш гэж бүлэгтийн үзэхэд 8 ба түүнээс дээш жирэмсэлийн тохиолдлын хэмжээ их байна. (25,7%; 36,6%  $P<0,01$ )

Үйлдвэрийн үйл ажиллагаа, нөхцөлтэй холбоотой өдрийн, өдөр-шенийн, шенийн ээлжийн ажилтай тохиолдлын үзүүлэлт 2 бүлэгт өдрийн ээлжийн ажилтай тохиолдолд бараг ялгаагүй, өдөр-шенийн ээлжийн ажилтай тохиолдол «өвчтэй» бүлэгт 33,5%, «эрүүл» бүлэгт 15,7%  $P<0,001$ , зөв хөн шенийн ээлж 3,5%; 0,8%;  $P<0,001$  тус тус олон тохиолдолтой байна. Үүнээс үзэхэд өдөр-шенийн, зөвхөн шенийн ээлжийн ажил нь үйлдвэрийн нөхцөлтэй холбоотой илрэх НХЗ болж байч.

Үйлдвэрийн янз бүрийн нөхцөл дангаараа тохиолдолд «эрүүл» бүлэгт 13,3%, «өвчтэй» бүлэгт 3,5% байгаа нь НХЗ болохгүй байна. Харин үйлдвэрийн хүнд нөхцөлүүдтэй хавсарсан тохиолдолд дээрх 2 бүлэгт 9,7%; 4,8%  $P<0,001$  өвчтэй илүү олон тохиолдолтой байна.

Хүн амын дунд артерийн даралт ихэссэн тохиолдол 160/95 мм МУБ ба түүнээс дээш артерийн даралт их 13,6% 140/90—159/94 мм МУБ завсрлын артерийн даралттай 6,3% байна. Артерийн даралт их тохиолдлын 3/4-д тархины судасны өвчний аль нэг хэлбэр илэрч байгаа буюу ТСӨ-ийг үүсгэгч судасны үндсэн өвчний дотор 42,2%-ыг өзөлж байгаагаас үзэхэд артерийн даралт ихсэх нь ТСӨ-ийг үүсгэх нөхцелдүүлэгч хүчин зүйл болохын хувьд зонхилох рольтой байна.

Дээр дурдсан хучин зүйлс нь аль нэг төрлийдээр хавсран тохиолдх хувилбаруудыг дээрх 2 булгийн хүн амд тус тусад нь судлахад хавсарсан тохиолдол нь ТСӨ-тэй хүн амын булэгт эрүүлээсээ бүр ч олон дахин тохиолдож байна. Гэхдээ НХЗ-ийн хавсарсан тохиолдлын хувилбараас хамаарч үзүүлэлтууд нь нилээд ялгаатай байна. Тухайлбал артерийн даралт ихсэх+архи уудаг+удамшлын сурвалжтай 12,5; артерийн даралт ихсэх+цусанд холестерины хэмжээ ихэссэн 12,3 дахин, артерийн даралт ихсэх+тамхи татдаг+өвчний удамшлын сурвалжтай 8,8 артерийн даралт+биений жин хэтэрсэн+удамшлын сурвалжтай 7,3; артерийн даралт ихэссэн+тарган 2,8; артерийн даралт ихэссэн+тарган+архи уудаг 8,0; артерийн даралт ихэссэн+тарган+зүрхний ишеми өвчин 3,0 дахин тус тус илүү тохиолдолтой байна. (Хүснэгт №2)

Ялангуяа артерийн даралт ихэссэн, биений жин хэтэрсэн, цусанд холестерины хэмжээ ихэссэн, архи тамхи хэрэглэдэг, өвчний удамшлын сурвалжтай зэрэг гол хучин зүйлс аль нэг хувилбараар хавсран тохиолдох нь уг өвчний үүсэл хөгжлийг нөхцөлдүүлэгч хучин зүйл болохын хувьд бүр ч илүү их рольтой байна.

Тодорхой хүн амын дунд ахуй цамьдралын дадал зуршил, тогтсон хэв маяг, уйлдвэрийн хортой хүнд нөхцөл, бие махбодийн дотоод үйл ажиллагааны өөрчлөлт зэргээс уламжилсан НХЗ нь өөрийн өвөрмөц шинж байдал, тэдгээрийн змгэг өөрчлөлт үүсгэх тоо хэмжээ, үргэлжлсэн хугацаа, хавсарсан тохиолдлын тэрэл, тоо зэрэг нь ТСӨ-ийг үүсгэн хөгжүүлэхэд шууд хамааралтайгаар холбогдож байна.

Тархины судасны өвчний нөхцөлдүүлэгч хучин зүйлсийн тархалтын үзүүлэлт, тэдгээрийн төрлийдээс хамаарч харилцан адилгүй байгаа боловч нийт дунгээр өндөр үзүүлэлттэй байгаа нь хүн амын түвшинд ТСӨ-ний анхдагч урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимтэй авч явуу лах асуудал зүй ёсоор тавигдаж байна.

Ашигласан хэвлэлийг зохиогчын хаягаар тодруулна уу?

ТОДОРХОЙ ХҮН АМЫН ДУНД ТСӨ-НИЙ  
НӨХЦӨЛДҮҮЛЭГЧ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ТАРХАЛТ

Нөхцөлдүүлэгч хүчин зүйлс	Тохиолдлын тоо	хувь
Нийт судлуулагчдын тоо	3100	100,0%
<b>1. Цусанд холестерины хэмжээ ихэссэн</b>		
6,49—7,76 ммолъ/л	87	2,8
7,77 ммолъ/л ба дээш	106	3,4
Бүгд.	193	6,2
<b>2. Тамхи татдаг: Өдөрт 1—10 ш</b>	705	22,7
11 ба түүнээс дээш	319	10,3
Бүгд.	1024	33,0
<b>3. Биеийн жин хэтэрсэн. (индекс Кетле)</b>		
26—29	486	15,7
30 ба түүнээс дээш	186	6,0
Бүгд:	672	21,7
<b>4. Артерийн дараалт ихэссэн: 140/90—159/90</b>		
мм МУБ	104	6,3
160/95 мм МУБ ба түүнээс дээш	423	13,6
Бүгд:	617	19,9
<b>5. Архи хэрэглэдэг (хааяа) (зөвхөн тэмдэглэлт өдөр, баяр ёслолоор, 1 удаа уухдаа</b>		
200 гр-аас ихгүй	559	13,0
байнга уудаг: (1 сард 2—3 удаа. I удаад 200 гр-аас дээш)	118	3,5
Бүгд.	677	21,5
<b>6. Удамшлын сурвалжтай: (эцэг эх) Тархинд</b>		
пүс харвах тасалдах	173	5,6
Артерийн дараалт ихэссэн	330	10,6
Зүрхний бах	33	1,1
Бүгд:	536	17,3
<b>7. Биеийн хөдөлгөөн идэвхгүй</b>	557	18,0
<b>8. 8 ба түүнээс дээш жирэмслэлттэй</b>	422	28,3
<b>9. Ээлжийн ажил: Өдөр шөнийн ээлж шөнийн ээлж</b>	603	19,5
	56	1,8
<b>10. Үйлдвэрлэлийн хүнд хортой нөхцөл хавсарсан</b>	175	5,6
<b>11. Давстай цай уудаг</b>	2604	84,0

## Хүснэгт № 2

**ТОДОРХОЙ ХҮН АЛЫГ ДУНД ТАРХИНЫ  
СУДАГНЫ ЭЗҮҮНИЙ НЭХЦӨЛДҮҮЛЭГЧ ХҮЧИН  
ЗҮҮЛСИЙН ХАВСАРСАН ТОХИОЛДОЛ**

Нэхцөлдүүлэгч хүчин зүйлсийн төрөл	Тархи су- даасны ,өвч- тэй** бүлэг		тархины судасны ,эрүүл** бүлэг		Эрүүл өвч- тэй бүлгүү- дийн харь- цаалсан тохиолд- лын хувь тоо
	тохиолд- лын хувь тоо	тохиолд- лын хувь тоо	узвүүлэлт		
Артерийн даралт ихэссэн цусанд Холестерины хэмжээ ихэссэн.	25	3,7	8	0,3	12,3
Артерийн даралт ихэссэн+цусанд холестерины хэмжээ нхэссэн+ +зүрхний ишеми өвчин.	18	2,7	=	=	=
Артерийн даралт ихэссэн+тар- ган+тамхи татдаг	, 39	5,8	26	1,07	5,4
Артерийн даралт ихэссэн+тамхи татдаг+удамшилын сурвалжтай.	10	1,5	4	0,01	8,8
Артерийн даралт ихэссэн+архи уудаг+удамшилын сурвалжтай	7	1,0	2	0,08	12,5
Артерийн даралт ихэссэн+тар- ган+удамшилын сурвалжтай	16	2,4	9	0,4	7,25
Артерийн даралт ихэссэн+тар- ган	42	6,2	53	2,2	2,8
Артерийн даралт ихэссэн+тар- ган+архи уудаг	27	4,0	12	0,5	8,0
Артерийн даралт ихэссэн+тар- ган+зүрхний ишеми өвчин	10	1,5	14	0,6	2,5
Артерийн даралт ихэссэн+тамхи татдаг+архи уудаг+тарган	6	0,9	1	0,03	3,0
Таван нэхцөлдүүлэгч хүчин зүйлс хавсарсан	6	0,8	=	=	=

НЭЭЛТТЭЙ ЗУРХНИЙ МЭС ЗАСЛЫН ҮЕД  
ЗУРХНИЙ МЭДРЭЛИЙН ДАМЖУУЛАХ СУДЛЫН  
АНATOMИЙН ТОГТОЦЫГ ТОДОРХОЙЛОХ АРГА

А. А. Мерунко, Н. Баасанжав,

В. В. Пекарский.

Анх 1985 онд зурхний мэдрэлийн дамжуулах судлын анатомийн тогтоцыг иодын уусмалаар тодорхойлох аргыг хэрэлзэжээ. (1) Өнөөлөр хүртэл туршилт ба клиникт зурхний мэдрэлийн дамжуулах судлыг хийжкуулсан иод түрхэн тодорхойлох үйлдлүүдийг хийсээр ирсэн хэдий ч төгс үр дунд хүрсэнтүй. (2,3).

Ажлын зорилго: хийжкуулсан иодоор зурхний мэдрэлийн дамжуулах судлыг тодорхойлох аргыг мэдээлэх.

Материал, судалсан арга: ховдол хоорондын таславчийн цоорхойтой 18 өвчтөнд судалгаа явуулав. Үүний 3 нь фаллогийн дээвэлсэн гажигтай. Судалгаанд хамрагдсан өвчтөн 3—12 настай. Биеийн жин: 12—27 кг. Дундаж нас  $6,6 \pm 3,1$  дундам жин;  $22 \pm 5,5$  кг Бүх өвчтөний биеийн халууныг бууруулсан нөхцөлд мэс засал хийсэн. Дундаж халуун нь  $26 \pm 21,50$  хэм. Зурхний хэндий венуудын цусны ургалыг хаасан хугацаа  $23 + 65$  мин. Зурхийн булчингийн агших чадварыг 16 мэкв/л калийн концентрацтай хавсарсан хүйтэн уусмалаар хамгаалсан. Ховдол хоорондын таславчийн цоорхойтой 18 өвчтөний 12-ыг баруун тосгуураар, 6-г баруун хөвдолоср мэс засал хийсэн.

Гажгийн байрлал: мембрран хэсгийн гурван хаваст хавхлагийн дотор талын 6, ховдлын гарах хэсэгт дээгүүр байрлалтай—9 бағз.

Зурхний цусны ургалыг хааж, зурхээ нээгээд гиийн судлыг дагуулан хийжкуулсан иодын уусмалыг цоорхойн ирмэгээс 2 мм зйтайгаар цоорхойн ирмэгийг оролцуулан 0,6 мг-зэс хэтрүүлэхгүйгээр түрхэж 1—2 мин ажиглав. (2)

Хийжүүлсэн иод турхээд зүрхний цахилгаан бичлэг хийж, цусанд иодын сорилыг тодорхойлов.

Ур дун. 18 өвчтөнд зүрхний мэдрэлийн дамжуулах судлыг хийжүүлсэн иод турхэн тодорхойлсон ур дүнг харуулав. (таблица—1) Хийжүүлсэн иодыг турхэхэд мэдрэлийн дамжуулах судал байгаа хэсэгт 2—3 мм өргөнтэй хүрэн ягаан зураас үүсч 5—10 минутын дараа арилж байлаад Клиникийн ажиглалтаар нэхөөс тавих ба цоорхойг оёх утсыг мэдрэлийн дамжуулах судлаас холуур авах боломжтой нь тодорхойлогдсөв. Судалсан 18 өвчтөнд иодын урвал нилрээгүй бамбай булчирхайн үйл ажиллагаа хэвийн. Мэс заслын дараа зурхний ЭКГ-ийн бичлэгт шудний эмгэг хэлбийлт илэрсэнгүй!

ДҮГНЭЛТ: Хийжүүлсэн иод нь зүрхний мэдрэлийн дамжуулах судлыг тодорхойлох боломжтойн гадна бие маш бодид ямар нэгэн хортой нөлөөгүй байна.

### АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

5. А. А. Мерунко, Н. Баасанжав, В. В. Пекарский.

1. Marchand F. Veber eine geschwilsins a vergestreiften maskefasern mit vngewohnlichen, genalte an glycogen nosst bemerkungen veber das glycogen in einigen fatalen geweben ” Virchows Arch. 1885—V. 42 P. 100

2. В. В. Пекарский, А. А. Марунко, А. В. Евтушенко и др. Способ приживленной визуализации проводящей системы сердца во время кардиохирургических операций в условиях гипотермической безперfusionной защиты). Новосибирск, из-во Наука, Сибирское отделение; Новые методы реконструктивной хирургии, тезисы Всероссийской конференции—1990—126 с.

3. Ishii K., Kurosawa H., et al. A new method of Vital staining of the conduction system ” J. Jpn. Assoc. thorac. surg. —1985 V. 33. —P. 467—476,

таблица—1

№	Өвчтөний овог нэр	Нас	Онош	Зурхий мэдрэлийн дамжуулах системийг будсан эсэх		Мэс залын дараа ЭКТ үзүүлэлт	Иодын сорил
1	К. Р. С.	3	Х. Х. Т. Ц-н мемброн хэ- сэгт	+	сину- ритмтэй	эмгэг хэлбийл- тгүй	
2	Г. Р. М.	6	баруун хов- лын гарах хэсэгт	+	—, —	—, —	
3	Ш. Е. И.	4	Х. Х. Т. Ц-н мемброн хэсэгт	+	—, —	—, —	
4	Р. В. И.	8	баруун ховд- лын гарах хэсэгт	+	—, —	—, —	
5	О. Ш. О.	5	—, —	+	—, —	—, —	
6	В. Н. К.	3	—, —	++	—, —	—, —	
7	Ц. Ю. П.	12	—, —	++	—, —	—, —	
8	З. В. С.	10	—, —	++	—, —	—, —	
9	И. Ш. С.	4	—, —	++	—, —	—, —	
10	П. М. И.	5	—, —	++	—, —	—, —	
11	Я. Ю. С.	6	3 хавтаст хавхлагын дотор талд	+	—, —	—, —	
12	П. А. В.	7	—, —	+	—, —	—, —	
13	Ж. Ц.	11	—, —	+	—, —	—, —	
14	Д. Б.	4	—, —	+	—, —	—, —	
15	Н. О.	8	—, —	+	—, —	—, —	
16	Б. О.	9	—, —	+	—, —	—, —	
17	С. М.	7	мемброн хэсэгт	+	—, —	—, —	
18	Ц. Э.	6	баруун ховд- гарах хэсэгт	+	—, —	—, —	

## ГАРЫН ХЭЭ БА СУРАХ ЧАДВАРЫН ХООРОНДЫН ХАМААРАЛ

АУИС-ийн биологи, удамзүй,  
дархлал судлалын тэнхим  
(эрхлэгч доц. И. Пүрэвдорж)

Алганы зураас, хурууны хээг хүн төрөлхтөн эртнээс сонирхон, хүний хувь тавилаа, заяа төөргийг түүгээр таах (хироманти) евчин эмгэгийг оношлох (дерматоглифик) зэрэгт ашиглахыг оролдссор иржээ. Ялангуяа хиромантийн урсгалд алганы зураасаар хүний оюун ухаан, авьяас чадварыг үнэлэх гэсэн оролдлого их байснаас «камжилтын», «авьяас чадлын», «оюун ухааны» шугам гэх зэрэг нэртэй зураас бий болсон байна. (5,6) Гэсэн хэдий боловч хурууны хээ, алганы зураас судлалын практикт түүний аль нэгэн үзүүлэлт нь хүний оюун ухаан, сэтгэн бодох чадвартай холбоотойг нотолсан шинжлэх ухааны баталгаа одоо болтол алга.

АУИС-ийн генетикийн сургалт судалгааны лабораторийт оюутнуудын гарын хээг тэдний сурх чадвартай холбон судлах ажлыг 10-аад жил хийж 3000 шахам хүнийг хамраад байна. Уг ажлын хэсгээс энд танилцуулъя.

Судалгаанд IV дамжааны оюутнууд хамрагдсан бөгөөд тэдний сурх чадвартыг үнэлэхдээ I II III дамжаяа буюу 6 улирлын 17—20 шалгалтын дүнгийн дунджаар авлаа. Үүнд: дундач дүн нь /

4,5—5 бол онц

3,7—4,4 сайн

3,0—3,6 дунд

3,0-аас бага бол муу гэж үнэлээд онц ба сайн сурдаг оюутнуудыг сурх чадвар сайтай, дунд, муу сурдаг оюутныг сурх чадвар тааруу гэсэн бүлэгт нэгтгэн авч үзлээ.

Хурууны хээг гарын хээ авах тогтоон аргаар тодорхойлж хээ бурийн давтамжийг судалгааны бүлэг тус бүрд тогтоож хурууны хээ сурх чадвар хоёрын хооронд хамаарал байгаа эсэхийг  $X^2$  ба шалгуурлар баталлаа. (I хүснэгт)

Хүснэгтээс харахад онц ба сайн сурдаг оюутнуудад углзан хээ (W) монголын хүн амын дунд илэрдэг давтамжаас (46,1%) (2,4) ул ялиг ихсэх (20,22%) хандлага ажиглагдсан боловч түүний үнэн магадлал сүл байв. Харин тааруу сурдаг (дунд, муу) оюутнуудын углзан хээний давтамж эрс буурч нуман (A) хээний давтамж илт нэмэгдэж байгаа нь анхаарал татаж байна. Тухайлбал углзан хээний давтамж сурх чадвар сайтай оюутнуудад 40,22% байсан бол тааруу оюутны бүлэгт 39,39% болж 1,3 дахин

буурсан ба нуман хээний давтамж сурхадарч чадвар сайтай оюутнуудад 3,07% тааруу оюутны бүлэгт 13,56 болж 4 дахиин оссөн байна. Ялангуяа энэ ялгаа нь муу сурдаг оюутнуудаас бурдэх бүлэгт илэрхийг ажиглагдаж байв. Жишээ нь: муу сурдаг оюутнуудад угалзан хээний давтамж 28,90% болтол буурсан байхад нуман хээний давтамж 27,20% болтол нэмэгджээ. Өөрөөр хэлбэл хүний сэтгэн бодох чадвар хурууны угалзан хээний давтамжтай шууц хамааралттай нуман хээний давтамжтай урвуу хамааралтай болох нь ажиглагдаж байна. Энэ хамаарал статистикийн өндөр магадгэлтэй ( $X^2=12,2$ ;  $P=0,005$ ) байв.

Гэтэл эрхий чигчий (R) ба (I) гогдоон хээний давтамж судалгааны аль ч бүлэгт өрөнхийдөө нэг түвшинд байгаа нь эдгээр хээ хүний сэтгэн бодох улмаар сурхадарч чадварт төдийлөн их нөлөөлдөггүй болохыг гэрчилж байна.

Тэрчлэн 10 хуруундаа нуман хээтэй хүн онц, сайн сурдаг оюутнуудын дунд огт илрээгүй атал дунд муу сурдаг оюутнуудын дунд тодорхой хэмжэггээр тааралдаж, 5-аас дээш хуруундаа нуман хээтэй хүн муу сурдаг оюутнуудын 28%-ийг эзлэж байхад онц сурдаг оюутнуудын дунд ийм хүн илрэхгүй байв.

Бидний судалгааны нийлбэр үзүүлэлт нь Монгол хүний гарын хээний давтамжийг судалсан судлаачдынхтай (2, 3, 4) өрөнхийдөө дүйж байгаа нь уг судалгаа бодитой хийгдсэндэйг харуулж байна.

Харин энэхүү нийлбэр үзүүлэлтуудийн лотроос бидний судалгаанд нуман хээний давтамж 7,56% буюу бусад судлаачдынхаас арай өндөр байгаа нь нэг талаас судалтаанд хамрагдсан хүмүүсийн дунд эм хүйсний хүн зонхицж байгаа, нөгөө талаас муу сурдаг бүлэг дэх хүний тоог зориуд олшруулж авсантай холбоотой.

Хэрэв сурхадарч чадвар, хурууны угалзан ба нуман хээний хооронд хамаарал байгаа нь үнэн бол  $D_{10}$  үзүүлэлт, сайн болсон тааруу сурдаг хүмүүст мөн ялгаатай байх ёстой.

$D_{10}$  0—20 хосронд хэлбэлзэх бегөөд нэг хүнт дундчлалыг хэцээн төрхийн (гурвалж) оногдохыг илэрхийлдэг үзүүлэлт юм. Жишээ нь: 10 хуруундаа нуман хээтэй хүнт  $D_{10}=0,10$  хуруундаа угалзан хээтэйхүнд  $D_{10}=20$  байна.

Бидний судалгаагаар  $D_{10}$  сайн сурслагатны бүлэгт 14,74, таалуу сурлагатны бүлэгт 12,58, бүр муу сурлагатны дунд 10,16 байгаа нь энэ үзүүлэлт сурхадарч чадвар хоёрын хооронд шууд хамаарал байж болохыг харуулж байна.

ЖУРУУНЫ ХЭЭ БА СУРАХ ЧАДВАРЫН ХООРОНДЫН ХАМЛАРАЛ

ХҮСНЭГТ 1

Сурах чадварын үнэлгээ

A

R

V

W

$$D_{x10} = \frac{A+2W}{A+V+W} \cdot 10$$

Хурууны хөзний хэлбэр

Очи 37	12 (3,24)	14 (3,78)	169 (45,67)	175 (47,29)
Сайн 116	35 (3,01)	36 (3,10)	491 (42,32)	528 (51,55)
сайн сайн = 153	47 (3,07)	50 (3,26)	660 (43,13)	773 (50,52)
Дунд 90	88 (9,77)	31 (344)	400 (44,44)	381 (42,33)
Мүү 25	68 (27,20)	10 (4,00)	100 (40,00)	72 (28,80)
тааруу тааруу	+115	156 (13,56)	41 (3,56)	500 (43,47)
Нийлбэр Үзүүлэлт 203 (7,56)	91 (3,39)	1160 (43,28)	1226 (45,74)	13,81

X<sup>2</sup> = 12,2;

P = 0,05

D<sub>10</sub>—үзүүлэлт дэлхийн улс үндэстнүүдэд 9,8—17,14 хооронд хэлбэлзэг ба монгол төрхийн хүмүүст уг үзүүлэлт ерөнхийдээ өндөр байдаг нь анхаарал татаж байна. Гухайлбал: Оросын буриад эрчүүдэд—15,16 (8) якут эрчүүдэд—15,24 (1) халх эрчүүдэд—15,21 (2) монголын нийт хүн амд—14,43 (3,4) байдаг ба Бразилийн индианчуудад хамгийн өндөр—17,24 илэрдэг ажээ. Ер нь D<sub>10</sub> үзүүлэлт Азийн ард түмэн, Бразилийн индианчууд Австралийн заамж уугуул омгийнханд өндөр давтамжтай илэрдэг нь тэгэнд W—хээ зонхилдгүй холбоотой.

Азиад угалзан хээ илрэх давтамж өмнөөс хойшоо, зүүнээс баруун чиглэлд улам ихэсдэг бөгөөд хамгийн өндөр давтамжтай газар нь төв Азийн бус нутаг Монгол орон ажээ.

**ДҮГНЭЛТ:** 1. Хүний сэтгэн бодох, улмаар сурхадаварт хурууны угалзан хээ—W эерэг нуман хээ—A серег нөлөөтэй байна!

2. Хүүхдэд ажил мэргэжлийн баримжааг зөв сонгохын гулд уг хүүхдийн журууны хээний байдлыг харгалзан үзэж байх нь зүйтэй.

### **МОНГОЛ ХҮНИЙ НЕЙТРОФИЛ ЭСИЙН ЗАЛГИХ ЧАДВАРЫГ ЭРҮҮЛ БА ЭМГЭГ ҮЕД СУДАЛСАН НЬ**

**Г. Батбаатар. д/э Б. Баяарт**

Монгол хүний дархлал тогтолцоо, түүний дотор залтих тогтолцооны үйл ажиллагааг судалсан ажил одоо хиргидээгүй байна.

Архаг халдварт олон өвчний үед дархлалын тогтолцооны үйл ажиллагаа алдагддагийг нейтрофил эсийн хөдлөх, залгих чадвар болон Т-эсийн тогтолцооны үйл ажиллагаа буурсантай холбоотой гэж судлаачид үздэг. (4,5)

Архаг халдварт өвчний улмаас бий болсон дархлалын тогтолцооны гажгуудыг сэргээх арга замуудыг судлаачид хайсаар байна. Ийм аргуудын нэг нь дархлалын тогтолцоонос ялгардаг өндөр молекулын нэгдэл лимфокин (иммунопептид)-ээр эмчлэх асуудал юм. (1,2)

Бид монгол хүний нейтрофил эсийн залгих чадварын хэвийн үзүүлэлтийг тогтоож улмаар архаг халдварт эмгэгийн үед уг үзүүлэлт хэрхэн өөрчлөгдхийт судалж бишкуу өөрчлөлтийг засан сэргээх арга замыг эрж хайх оролдлого хийсэн юм. Энэ зорилгын үүднээс эрүүл хүний нейтрофил эсийн залгих чадварыг латексийн аргаар тодорхойлж үр дүнг гадаадын судлаачдын гаргасан үзүүлэлттэй харьцуулж үзэв.

Судалгаанд 17—54 наасны эрэгтэй, эмэгтэй 203 хүн хамрагдсан бөгөөд нейтрофил эсийн идэвхийг залгилтын тоо (ЗТ), залгилтын индекс (ЗИ)-ээр тодорхойлсон болно. (Хүснэгт 1)

Хүснэгт 1, Эрүүл хүний нейтрофил эсийн залгих чадварын

үзүүлэлт.

	15—24 н n=56	25—34 н n=45	35—44 н n=28	45—54 н n=8
ЗТ	эм 49,9±5,7%	51,7±5,1%	51,7±5,6%	49,7±4,2%
	эр 49,2±4,9%	49,2±3,6%	49,3±3,7%	
ЗИ	эм 2,05±0,20	2,16±0,25	2,03±0,19	2,0±0,05
	эр 1,94±0,14	1,93±0,11	1,93±0,21	

Бидний судалгаагаар нейтрофил эсийн залгих чадварын үзүүлэлт эрүүл эрэгтэй хүнд ЗТ  $49,2 \pm 4,4\%$ , ЗИ  $1,94 \pm 0,15$ , эрүүл эмэгтэй хүнд ЗТ  $50,7 \pm 4,4\%$ , ЗИ  $2,06 \pm 0,22$  байлаа. Үүнийг гадаадын зарим судлаачдын (3,6) үзүүлэлтэй харьцуулахад ЗТ 20%-иар, ЗИ бараг 2 дахин өндөр байв. Өөрөөр хэлбэл монгол хүний нейтрофил эсээс 2 дахин их латекс залгих чадвартай болох нь харигдаж байна. Энэ нь байгаль цаг уурын хатуу ширүүн нөхцөлд амьдарч аж төрдөг монгол хүний бие махбодийн нэгэн өвөрмөц онцлог байж болох талтай.

Сүрьеэ, архаг бронхит, шүд-амны хөндийн зарим архаг үрэвсэлт өвчтэй хүмүүст нейтрофил эсийн залгих чадварыг тодорхойлж эрүүл хүний үзүүлэлттэй жишиж судаллаа.

Хүснэгт 2. Зарим архаг үрэвсэлт өвчний үеийн нейтрофил эсийн залгих чадварын үзүүлэлт.

	Сүрьеэ өвчтэй хүмүүс	Шүд+амны хөн дий үрэвсэлт өвчтэй хүмүүс	Архаг брон хит өвчтэй хүмүүс	Эрүүл хүмүүс
ЗТ	22,0±2,2%	30,1±3,1%	35,9±3,9%	50,7±4,4%
ЗИ	1,58±0,18	1,80±0,17	1,80±0,08	2,06±0,22

Дээр дурьдсан архаг халдварт эмгэгүүдийн үед нейтрофил эсийн залгих чадвар 27—54% буурсан байв. Дархлалийн тогтолцсоны энэхүү гажгуудыг засан сэргээх зорилгоор хүний лимфоцит эсийн 20—22 цагийн өсгөвөрийн шингэнээр үйлчилсний дараа нейтрофил эсийн залгих чадварыг дахин шалгаж үзэхэд тогтолцсоны үйл ажиллагаа 35—65% эргэн сэргэсэн байлаа. (Хүснэгт 3) Энэ нь эсийн өсгөвөрийн шингэнд нейтрофил эсийн залгих чадварыг сэргээдэг лимфокин агуулагдаж байгааг гэрчилж байна. Туүнийг цэвэрээр ялган авч архаг халдварт эмгэгүүдийн үед хэрэглэх нь эмчилгээний сайн үр дүнтэй болохыг бидний судалгаа харууллаа. Харин лимфоцит эсийн 20—22 цагийн өсгөвөрийн шингэн эрүүл хүний нейтрофил эсийн залгих чадварт онцын нөлөө үзүүлэхгүй байна.

**Хүснэгт 3. Лимфоцит эсийн өсгөвөрийн шингэнээр нейторфил эсийн залгих чадварт нөлөөлсөн нь.**

	ЗТ		ЗИ	
	1	2	1	2
Эрүүл	50,7±4,4%	55,7±4,5%	2,06±0,21	2,46±0,16
Сүрьеэ	18,3±1,7%	30,8±2,6%	1,42±0,10	1,76±0,10
Шудний гаралтай үрэв- сэлт өвчин	31,3±3,2%	47,8±4,4%	1,65±0,16	2,29±0,2
Архаг бронхит	35,9±3,9%	50,3±3,3%	1,80±0,08	2,32±0,33

1—контроль

2—өсгөвөрийн шингэнээр үйлчилсний дараа

### ДҮГНЭЛТ

1. Эрүүл хүний нейтрофил эсийн залгих чадварын хэвийн үзүүлэлт нь бидний урьдчилсан байдлаар тодорхойлсноор эрэгтэйд ЗТ  $49,2\pm4,4\%$ , ЗИ  $1,94\pm0,15\%$ , эмэгтэйд  $50,7\pm4,4\%$ , ЗИ  $2,06\pm0,22$  байна. 2. Лимфоцит эсийн 20—22 цагийн өсгөвөр шингэнд залгигч эсийн үйл ажиллагтаанд нөлөөлдөг идэвхгэй фракц агуулагдаж байна. 3. Сүрьеэ, архаг бронхит, шуд-амны хөндийн архаг үрэвсэлт өвчний үед нейтрофил эсийн үйл ажиллагаа ихээхэн буурдат бөгөөд үүнийг лимфокин агуулсан эсийн өсгөвөрийн шингэнээр засан сэргээх боломжтой.

**МОНГОЛ ХҮНИЙ ЛИМФОЦИТЫН ДЭД БҮЛГИЙГ  
ЭРҮҮЛ БА ЭМГЭГ ҮЕД НЬ СУДАЛСАН НЬ**

Д. Энх-Амар, д/э Б. Баярт

Т. Лимфоцит, (Тлф), түүний дэд бүлгийн (субцопуляци хэмжээг тодорхойлох нь өвчний онош тавилан чухал ач холбогдолтой бөгөөд явуулж буй эмчилгээний үр дүнг тооцох боломж олгодог).

Монгол хүмүүсийн дархлалын тогтолцооны хэвийн хэмжээ, тухайлбал Тлф, түүний дэд бүлгийн хэмжээг тогтоох талаар хийсэн судалгаа бага байна. Бидний судалгааны зорилго нь эрүүл ба янз бурийн эмгэгийн үед Тлф, түүний дэд бүлгийн хэмжээг тодорхойлох явдал байв. Үүний тулд 1. Эрүүл хүний Тлф, түүний дэд бүлгийн түвшинг тогтоож, 2, аутоиммун зарим өвчин, мэс заслын идээт архагт өвчнүүдийн үед эдгээр үзүүлэлтүүдийг тодорхойлсон юм.

Эрүүл хүний үзүүлэлтийг тодорхойлоходоо 17—54 насны 82 эмэгтэй, 28 эрэгтэй, нийт 110 хүн судалгаанд хамруулан Тлф-ифг хүрээ үүсгэх (розеткообразование (2), Тлф-ийн дэд бүлгийг теофиллийн аргаар (4) тодорхойлсон болно. (Хүснэгт 1)

1 хүснэгт. Эрүүл хүний Тлф түүний дэд бүлгийн хэмжээ

		17—24 нас	25—34 нас	35—44 нас	45—54 нас
Тлф %	эм	56,3±4,8	51,6±4,9	46,7±4,2	51,3±4,9
	эр	59,6±4,8	56,8±5,2	47,7±4,3	52,5±5,1
Tx %	эм	44,1±3,8	37,3±3,5	36,0±3,5	42,5±4,1
	эр	44,1±3,8	44,0±3,9	40,0±3,9	43,2±4,1
Tc %	эм	15,5±1,3	14,4±1,2	18,9±1,2	14,0±1,3
	эр	13,0±1,2	17,5±1,6	11,0±1,1	12,5±1,1
Tx/Tc	эм	2,4±0,2	2,9±8,2	2,2±0,2	3,7±0,3
	эр	3,5±0,3	2,5±0,2	4,4±0,3	2,9±0,3
		Тлф %	Tx %	Tc %	Tx/Tc
		эм	51,4±4,5	40,2±3,9	15,7±1,3
		эр	54,5±5,1	42,9±4,1	13,8±1,3

Хүснэгтээс үзэхэд Тлф түүний дэд бүлгийн хэмжээнд насны байдлаас хамаарч өөрчлөлт их гаралгүй байна. Эрэгтэй хүмүүсийн Тлф Тхеллер (TX-ийн хэмжээ бага зэрэг их байна. Эмэгтэй хүмүүст Т супрессор (Tc)-ийн хэмжээ их байгаа нь эстроген дааврууд эдгээр эсийн дараангуй-40

лах нөлөө г идэвжүүлж байдагаар тайлбарлаж болох юм.

Судалгааны үр дүнг гадаадын зарим судлаачдын (3) үзүүлэлттэй харьцуулахад Тлф-ийн хэмжээ 10%-иар өндөр, бусад үзүүлэлтүүд онцын ялгаагүй байв.

Атоиммун зарим өвчтэй хүмүүст Тлф-ийн дэд бүлгийг стационарын нөхцөлд эмчлүүлж байсан 18—51 наасны 7 эмэгтэй, 4 эрэгтэй, нийт 11 өвчтөнд шинжилгээ хийж судлав. Эрүүл хүмүүстэй харьцуулж үзэхэд (узвизт?) Тх-ийн хэмжээ 3—4%-иар, Тс-ийн хэмжээ 8—10%-иар буурч, Тх% Тс-ийн харьцаа 2,6—3,4-өөр нэмэгдэв. Тс-ийн хэмжээ ихээр буурах нь Тх-ийн аутореактивный Тлф-ийг идэвхжүүлэхэд эмгэг илрэх нэг нөхцөл болно.

Мэс заслын идээт архаг халдвартай стационарын нөхцөлд эмчлүүлж байсан 18—60 наасны 5 эмэгтэй, 8 эрэгтэй, нийт 13 өвчтөнүүдийн Тлф-ийн дэд бүлгийт судалж үзэхэд Тх-ийн хэмжээ 18—20%-иар буурч, Тс-ийн хэмжээ 10—12% иар ихэсч, Тх/Тс-ийн харьцаа 2,2—2,6%-иар буурсан байв. Тх-ийн хэмжээ буурах, Тс-ийн хэмжээ ихсэх нь халдвартын эсрэг хамгаалалтанд оролцдог эсийн дархлалын гүйцэтгэгч механизмууд дарангуйлагдах нөхцөл болно.

2-р хүснэгт. Тлф түүний дэд бүлэг янз бурийн эмгэгийн  
үед өөрчлөгдөх нь

	Тлф%	Tx%	Tc%	Tx/Tc
Атоиммун өвчин	38,6±2,4	36,9±1,4	5,4±0,4	6,1±0,6
Мэс заслын идээт архаг халдвар	32,2±2,7	20,9±1,6	27,8±2,4	0,7±0,4
Эрүүл	52,9±5,0	41,6±2,8	14,8±1,3	3,1±0,2

## ДҮГНЭЛТ

1. Эрүүл хүний Т лиммоцит, түүний дэд бүлгийн хэвийн хэмжээ бидний урьдчилсан байдлаар тодорхойлсноор эрэгтэйд Тлф  $51,4 \pm 4,5\%$ , Tx— $40,2 \pm 3,9\%$ , Tc— $15,7 \pm 1,3\%$  Tx/Tc— $2,8 \pm 0,2$  Эмэгтэйд Тлф— $54,5 \pm 5,1\%$ , Tx— $42,9 \pm 4,1\%$ , Tc— $13,8 \pm 1,3\%$ , Tx/Tc  $3,4 \pm 0,3$

2. Атоиммун зарим өвчтэй хүмүүст Тс их хэмжээгээр буурах Тх-ийн аутореактивный Тлф-ийг идэвхжүүлэх эмгэг үйлчлэл илрэх нэг нөхцөл болно.

3. Мэс заслын идээт архаг халдвартын үед Тх-ийн хэмжээ буурах, Тс-ийн хэмжээ ихсэх нь эсийн дархлалын гүйцэтгэгч механизмууд дарангуйлагдах нөхцөл болно.

## АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Беклемишев Н. А. Иммунопатология и иммунорегуляция. М. Медицина 1986. С 109—110.
2. Закс А. С., Быкова А. А. Экспресс метод определения количества Т и В лимфоцитов в крови человека. Лаб дело 1984 №4 С 242—243
3. Лебедев А. К., Понякина И. Д. Иммунограмма в клинической практике М. Нука 1990 С 68—72, 168
4. Неприна Г. С., Пантелеева Е. С., Ярилин А. А., Взаимосвязь чувствительности к теофиллину и экспрессии Fc и Fc рецепторов Тлф-ов человека в норме.
5. Скрябина Э. Г. Количественная сменка субпопуляций Т лимфоцитов в диагностике и выборе способа коррекции нарушений иммунорегуляторного звена. Автореф. дисс. канд. мед. наук. Москва 1987. с 16—19.

### УМАЙН ГАДУУРХИ ЖИРЭМСНИЙ ЭМНЭЛЗҮЙ ТАВИЛАН

Б. Шижирбаатар, Б. Жав,  
Самди Сурия

Эмэгтэйчүүдийн өвчний гаралтай хэвлэлийн цочмог үрэвсэлт өвчинүүдийн дотор умайн гадуурхи жирэмсэн тэргүүн байранд орж байна. 1979—1988 онд Улаанбаатар хотын нэгдүгээр нярайлах газрын эмэгтэйчүүдийн тасагт эмчлүүлсэн нийт өвчтөний 1,3% нь, мэс засал хийлгүүлсэн тохиолдлын 33,7%-ийг умайн гадуурхи жирэмсэн эзэлж, өвөл хаврын улиралд илүүтэй тохиолдож байна.

Умайн гадуур жирэмсэлсэн 100 өвчтөний 88% нь 25—39 насны, 57% нь ажилчн, 42% нь албан хаагч, 1% нь суралцаагсад байна.

Сарын тэмдэг анх ирсэн насаар нь ялгахад 11—12 настай  $3 \pm 1,7\%$ , 13—14 насанд  $39 \pm 4,9\%$  15—16 настайд  $53 \pm 5,0\%$ , 17—18 насанд  $5 \pm 2,2\%$  эзэлж байна.

Умайн гадуур жирэмсэн сноштой 100 өвчтөний  $30 \pm 4,6\%$  нь шууд оношлогдсон,  $52 \pm 5,0\%$  ийг сэжиг бүхий хэмээн эмнэлэгт хэвтүүлсэн юм.  $16 \pm 3,7$  нь умайн дайврын үрэвсэлтэй,  $11 \pm 3,14\%$  нь эхэлсэн зулбаатай,  $5 \pm 2,2\%$  нь умайн хоргуй хавдартай,  $3 \pm 1,7\%$  нь умайн үйл ажиллагааны алдагдлын цус алдалттай,  $2 \pm 1,4\%$  нь умайн жирэмсэн,  $1 \pm 0,99\%$  нь ихсийн гаралтай ургацагтай гэсэн оноштойгоор эмнэлэгт хэвтсэн байв.

Нийт өвчтөний зонхилох хэсгийн бэлгийн харьцаанд орсон дундаж нас  $20,5 - 0,28$  байна. 4% орчим нь бэлгийн харьцаа тогтмол хийдэггүй байв. 91% нь анхныхаа нөхөртэй 9% нь хоёрдахь нөхөртэй суусан байлаа.

Доор дурдсан эрхтэн системийн өвчинүүдээр өвчилжээ. Нийт өвчтөний  $68 \pm 4,7\%$  нь улаан бурхнаар,  $54 \pm 6,0\%$  нь бахлуураар,  $5 \pm 2,5\%$  нь улаанууд томуугаар,  $39 \pm 4,9\%$  чь салхин цэцгээр,  $21 \pm 4,0\%$  мухар олгойн үрэвслээр,  $20 \pm 4,0\%$  нь хатгалгаагаар,  $23 \pm 4,2\%$  нь элэгний үрэвслээр,  $13 \pm 3,4\%$  нь плиелонефритээр,  $3 \pm 1,7\%$  цөсний хүүдлийн үрэвслээр тус тус өвчилсөн байна.

Бүх өвчтөний  $6 \pm 2,4\%$  нь үтрээн үрэвслэлтэй,  $33 \pm 4,7\%$  нь умайн хүзүүний шархлаатай,  $17 \pm 3,8\%$  нь умайн салсны үрэвсэлтэй,  $25 \pm 4,3\%$  нь дайвруудын үрэвсэлтэй,  $15 \pm 3,6\%$  нь өндгөвчийн уйланхайтай,  $21\%$  нь өндгөвчийн жижигхэн уйланхайцарт маягийн өөрчлөлтүүдтэй тус бүр  $1 \pm 0,99\%$  нь умайн булчингийн ба өндгөвчийн хоргүй хавдар, бэлэг эрхтэний дутмаг хөгжилтэй, 6% умайн гадуурхи жирэмсний учир мэс засал хийлгэсэн байв.

Нийт өвчтөний дотроос  $7 \pm 2,5\%$  нь жирэмсэлж байгаагүй,  $23 \pm 4,2\%$  нь хоёрдогч үргүйдэлтэй,  $43 \pm 5,0\%$  нь жирэмсэлсэн ба үр хөндүүлсэн,  $42 \pm 4,9\%$  нь умайн гадуур жирэмсэлсэн,  $4 \pm 1,9\%$  нь үр хөндүүлсэн болсон умайн гадуур жирэмсэлсэн анамнезтэй байлаа.

Умайн гадуурихи жирэмсний илрэх шинж олон янз байна. Бүх өвчтөний  $99 \pm 0,99\%$ -д өвдөх шинж илэрсний  $86 \pm 3,5\%$ -д хэвллийн доод талаар базлах,  $6 \pm 24\%$ -д үнжирсан,  $2 \pm 1,4\%$ -д байнга өвдөх хэлбэртэй шинжууд давамгайлж байна. Өвдөлт бүсэлжий ( $65 \pm 4,8\%$ ), гуя ( $24 \pm 4,3\%$ ) хошного ( $13,3 \pm 3,4\%$ ) тийш дамжих илүүтэй байна. Өвчтөний  $27,8 \pm 4,5\%$ -д Шеткин-блюмбергийн,  $35 \pm 4,8\%$ -д хэвллийн өмнөт хананы булчингийн хүчдэлтийн шинж тод илэрч байв.  $71 \pm 4,7\%$ -д бие суларч толгой эргэх,  $30 \pm 4,6\%$ -д түр зуур ухаан балрах,  $50 \pm 5,0\%$ -д чих шуугих,  $57 \pm 5,0\%$ -д харанхуйлж бүрэлзэх шинжууд давуутай илэрсэн юм.  $62 \pm 4,8\%$ -д сарын тэмдэг хоёр хүртэл болон 9 долоо хоногоос дээш хугацаанд хоригдсон,  $6 \pm 2,4\%$ -д хошного руу тулж өвдөх, шингэнээр гүйлгэх шинж илэрнэ.

Умайн гадуур жирэмсэн болсон бүх өвчтөний хэвтэх үеийн биенийн байдал  $67 \pm 4,7\%$ -д хөнгөн,  $15 \pm 3,6\%$ -д дунд зэрэг,  $18 \pm 3,8\%$ -д хүнд байлаа. Арсыны өнгө  $33 \pm 4,7\%$ -д хэвийн,  $67 \pm 4,7\%$ -д цагаарсан,  $12 \pm 3,2\%$ -д хөх ялимгүй хатуурсан биенийн халуун  $78,8 \pm 4,4\%$ -д хэвийн,  $18,8 \pm 4,2\%$ -д

ихэссэн байв. Судасны цохилтын тоо  $2,2 \pm 2,4\%$ -д удааширсан буюу нэг минутанд 60-аас доош,  $62,2 \pm 51,1\%$ -д нь 81—120 ба түүнээс дээш түргэссэн,  $35,5 \pm 5,0\%$ -д хэвийн хэмжээнд байв.

Умайн гадуур жирэмсэлсэн нийт өвчтөний артерийн даралт  $107 \pm 2,2 / 69,3 \pm 1,6$  мм МУБ,  $94 \pm 2,4\%$ -д цусархаг ялгадастай,  $73 \pm 4,7\%$ -д арын хүнхрээгээр хөндүүрлэх,  $67 \pm 4,9\%$ -д умайн хүзүүг хөдөлгөхөд өвдөх шинж илэрсэн юм. Умайн хэмжээ  $57 \pm 4,9\%$ -д хэвийн,  $43 \pm 4,9$  -д нь ялимгүй томорсон. Нэг өвчтөнд умай 15—16 долоон хоногтой жирэмсний хэмжээтэй томорсон нь дайвар угалзны жирэмсэн байв.

Умайн гадуур жирэмсэлсэн эмэгтэйчүүдийн цусны шинжилгээнд мэдэгдэхүйц хазайлт гарч байна. Тухайлбал цусны улаан бөөм, гемоглобины тоон үзүүлэлт цоорч, цагаан эс ба тромбоцитын тоо харьцаангуйгаар олшрох, улаан эс тунах хурд түргэсэх өөрчлөлтөөр илэрч байна. Эрүүл жирэмсэн эмэгтэйхтэй харьцуулахад цусан дахь ерөнхий уургийн дундаж хэмжээ, тухайлбал гамма глобулин ихсэх ( $P < 0,001$ ), альфа глобулин бағасах ( $P > 0,001$ ), альбумин-глобулины коэффициент буурах шинжүүд давамгайллан илэрч байна. Глобулин альфа ба ветта ( $P > 0,05$ ) байна.

Бүгд 85 өвчтөнд утрээгээр арын хүнхрээнд хатгалт хийснээс 87 (95%) өвчтөнд хуучин цус (нөжирсөн) гарч оноши батлагдсан ба хоёрдахь хатгалт 3 (3,5%) хүнд хийхэд шингэн цус гарсан 1 (1,2%) хүнд гуравдахь хатгалт хийхэд цус гаралгүй байна.

Хэт авианы шинжилгээгээр өвчтөний 70,3%-д нь дайварт эхо-хасах, 29,7%-д Эхохолимог (нэмэх, хасах), 24,3%-д умай шулууун гэдэсний хоронд эхохасах үүсвэр оношлогдсон байна. Умайн салст бүрхүүлийн гистологийн шинжилгээгээр бүх өвчтөнд цэлмэн, хорион илрээгүй байна. Харин 87,5%-д нь салстын үйл ажиллагааны давхар үрчийж судас мушгирсан, 12,5%-д салст бүрхүүлийн булчирхайлаг гиперплази илэрчээ.

Умайн хүзүүний сувгийн ялгадсанд хийсэн бактерлогийн шинжилгээ олонх тохиолдолд ( $30 \pm 8,4$ ) гэдэсний савханцар цөөнхөнд нь алтлаг стафилококк А бүлгийн стрептококк тус тус ( $3,3 \pm 3,2\%$ ) илэрсэн байна.

Хэвллийн хөндийт нээхэд 97 өвчтөнд умайч түурс хагарсан, 57 өвчтөнд умайн гуурсын өргөссөн, 37 өвчтөнд нарийссан хэсэгт, 3 өвчтөнд умайн ханын байрлалтай байжээ. Умайн дайврын үрэвсэл (56%), нөгөө талын гуурс угүй (5%), өндгөвч хагарсан (4,9%), жирэмсэн гуурс наал-

дангитай ( $39 \pm 4,8\%$ ), жирэмсэн үгүй гуурс наалдангатай ( $14 \pm 3,5\%$ ), мухар олгойн улайх үрэвсэлтэй (1%) зэрэг эмтэгт өөрчлөлтүүд илэрсэн байна.

Мэс засал хийсэн өвчтөний олонхид нь ( $73 \pm 4,4\%$ ) гуурсыг авч, цөөнхи тохиолдолд 2 гуурс авах ( $10 \pm 3\%$ ), гуурсыг нөхөн үлдээх ( $4 \pm 1,9\%$ ) зэрэг үндсэн мэс ажилбарын зэрэгцээ хүндрэлээс шалтгаалан өндгөвч авах ( $41 \pm 5\%$ ), сэмж тайрах ( $13 \pm 3,4\%$ ) хэвллийн хөндийд гуурс тавих ( $15 \pm 3,6\%$ ) мэс ажилбарууд хийгдсэн байна. Мэс заслын дараа 96 өвчтөнд хүндрэл гарцаагүй ба тус бүр I өвчтөнд уушгины хатгалгаа, венийн үрэвсэл, арьсан доорх өөхөн эслэгт цус хурах, шулуун гэдэс цоорх хүндрэл гарсан.

Мэс заслын дараах 4—5 дахь өдрөөс сэргээн сайжруулах I шатны эмнэлэг урьдчилан сэргийлэх арга хэмжээ бүх өвчтөнд эхэлсэн ба цөөн тохиолдолд II шатны (1—2 сар), III шатны (3—4 сарын дараа) шинжилгээнүүд хийсэн юм.

Дээрхээс үзэхэд умайн гаднах жирэмслэлт цаашдаа нэмэгдэх хандлагатайн дээр эмнэл зүй будэг илэрдэг хэлбэр ихсэж, хүндрэл таан тохиолдож байгаа болон мэс заслын дараах наалданга, үрэвсэлт өвчин, ургуйдэл зэрэг хортой нөлөө их байгааг харгалzan үзэж, умайн гаднах жирэмслэлт тохиолдож болзошгүй өртөмтгий эмэгтэйчүүдийн бүртгэл судалгаа тарган урьдчилан сэргийлэх эмчилгээ хийх, хяналтаанд байлгах шаардлагатай байна.

## Лекц Тойм Зөвлөгөө

### МЭРГЭЖИЛ СОНГОЛТОНД СЭТГЭЦ ФИЗИОЛОГИЙН СОРИЛ ХЭРЭГЛЭХ АЛХАМ.

Доц Г. Сүхбаат  
Багш О. Амарцэнгэл

Зах зээлийн эдийн засгийн өнөө үед хүний хүчин зүйлийн үүрэг улам өсөн нэмэгдэж, хөдөлмөрийн бүтээмжийг зайлшигүй дээшлүүлэх нийгэм эдийн засгийн шаардлага хурцаар тавигдах боллоо.

Хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт юуны урьз шинэ техник технологийг нэвтрүүлэх, тэдгээрийг чадамгай эзэмшиж, улам боловсронгуй болгох чадалтай мэргэжлийн боловсон хүчинээс хамаардаг. Иймээс ч өндөр хөгжилтэй орнууд техник технологоо дээд зэргээр боловсронгуй болгохын зэ-

рэгцээ, ирээдүйн мэргэжилтэнг шилж сонготх ажлыг шинжлэх ухааны ихээхэн нарийн үндэслэлтэй явуулдаг ажээ. Одоогоос 90 шахам жилийн тэртээ АНУ-ын Гарвардын их сургуулийн проф. Мюнценберг вагоны дарга нарын сэтгэц физиологийн онцлогийт судалснаар мэргэжил сонголтыг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулах судалгааны эхлэл тавигджээ. Шинжлэх ухааны үндэстэй мэргэжил сонгох ажил дэлхийн I дайны үеэс эхлэн АНУ, Франц, Герман, Швейцарт 1930-аад оны үеэс хуучин ЗХУ-д нийлээд өргөжин өнөөг хүртэл дэлхийн хөгжилтэй бүх оронд мэдэгдэхүйц хөгжиж, тэр ч байтугай өдөр бүр ажилдаа тэнцэж тохирох боломжтой эсэхийг ч урьдчилан тогтоочихдог болжээ. (7, 8, 4, 9, 10). Өнөөдөр манай хойт хөрш ОХУ-д гэхэд л мэргэжил сонгох, баримжаалах чиглэлээр 10 шахам эрдэм шинжилгээний хүрээлэн ажиллаж, эмнэлэг физиологийн, сэтгэцийн, нийгэм эдийн засгийн, эрх зүйн чиглэлээр судалгаа шинжилгээний ажил явуулж байна. (2,7)

Сүүлийн жилүүдэд мэргэжил сонготх, сургалтын үйл явцыг боловсронгуй болгоход сэтгэц физиологийн сорилтуудыг (аргуудыг) өргөн хэрэглэх боллоо. Тухайлбал спортын ур чадварын өсөлт дээд мэдрэлийн үйл ажиллаааны онцлогоос (5) оюутны сурлагын амжилт мэдрэлийн үйл ажиллагааны хүчинээс, ой ухаанаас (3,8) хамаардаг болохыг тогтоожээ.

Мэргэжил сонготх ажлыг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах асуудал зөвхөн нийгэмд ашигтай төдийгүй хувь хүнд ч маш их өгөөжтэй. Хэрвээ өөртөө тохирох мэргэжлийг зөв сонгож чадвал тухайн хүн өөрийнхөө хэрэгцээг бүрэн дүүрэн хангаж, нийгэм хамт олны дунд зохих байраа эзлэж, нийгэмд хэрэгтэй хүн гэдгээ ухамсарлахын зэрэгцээ эрүүл мэндээ хамгаалж бэхжүүлэх ихээхэн боломж гарч ирдэг ажээ. (7, 6, 9)

Мэргэжлээ зөв сонгож чадаагүй тохиолдолд дээр дурдсан ур өгөөж илрэхгүй бөгөөд өндөр мэргэжлийн хүмүүс эрүүл мэндээрээ тэнцэхгүй жагсаалаас эрт гарах тохиолдол багагүй байдаг. Үүний зэрэгцээ хүний физиологи, сэтгэл зүйн боломжийг бодолцохгүй техник технологийг огцом өөрчлөх нь хүний эрүүл мэндэд хор уршигтайг сүүлийн үед эрдэмтэд анхаарах боллоо. (9,2) Манайд сургуульд элсэгчдийн уралдаант шалгалт, эрүүл мэндийн үзлэг хоёрыг эс тооцвол мэргэжил сонгох ажлын шинжлэх ухааны үндэслэл өнөөг хүртэл орхигдож иржээ. Дээр дурдсан баримт сэлт нь манай оронд ирээдүйн мэргэжилтэнг шилж сонгох шинжлэх ухааны үндэслэл өөрийн гэсэн аргачлал зайлшгүй шаардлагатайг харуулж байна. Үнээс үүдэн бил хамгийн

энэрэнгүй ёсны мэргэжил-хүний их эмч болох хүмүүсийг шилж сонгох сэтгэц-физиологийн сорил боловсруулан судалгаа явуулах зорилт тавилаад:

Уг сорилыг сэтгэц-физиологийн сорил боловсруулах үндсэн шаардлагуудыг бодолцон, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарим сорилоос үлгэр авч, «Анагаах ухааны дөрвөн үндэс» номонд өвчнийг анагаагч эмчийн орны шалтгааныг: оюун нь төгөлдөр, сэтгэл нь цагаавтар, зорилго нь тод, ажилдаа хичээнгүй, совор нь төв гэж үзсэнтэй уялдуулан 5 бүлэг, 31 асуулт, 93 хариултгайгаар зохиож үнэн зөвийг шалгах түлхүүртэйгээр боловсрууллаа. Уг сорил бодит эсэхийг практикт туршихаар АУИС-ийн 187 элсэгчид, 800 оюутан, 60 төгсөгчдийг (эмч багш нар, мэргэжигч оюутнуудад) хамааруулан судалгаа явуулж үр дүнг нь компьютерт тусгай программаар боловсрууллаа.

Судалгааны үр дүнг авч үзвэл:

Сэтгэц-физиологийн шалгуураар судалгаанд хамарагдсан 800 оюутаны 15% нь эмчийн мэргэжилд бүрэн тэнцэх, 66,4% нь тэнцэх боломжтой, 18,62% нь тэнцэхгүй гэсэн үзүүлэлт гарлаа. Эмэгтэйчүүдийг (16,45%) эрэгтэйчүүдтэй (13,02%) харьцуулахад бүрэн тэнцэх боломжийн хувьд харьцангуй давуутай байна. Эмч мэргэжлийн багш нар, мэргэжигч оюутнуудын бараг гуравны нэг нь (28,3%) бүрэн тэнцэж зөвхөн нэг хүн тэнцэхгүй гэсэн үнэлгээ авсан нь бидний боловсруулсан сорил үнэн бодитойг илтгэж байна. Элсэгчдийн дотор сэтгэц физиологийн шалгуураар эмчийн мэргэжилд тэнцэх хүмүүс олон (38%) байгаа ч уралдаант шалгалтаар тэр болгон тэнцдэгтүй бололтой (Хүснэгт 1):

#### Хүснэгт № 1

Сэтгэц-физиологийн шалгуураар Эмчийн мэргэжилд тэнцүүлсэн нь

Зэрэглэл	Элсэгчид		Төгсөгчид		Оюутнууд	
	п	%	п	%	п	%
Тэнцэхгүй	19	10,2%	1	1,7%	149	10,6%
Тэнцэх	97	51,9%	42	70,0%	531	66,4%
Бүрэн тэнцэх	71	38,0%	17	28,3%	120	15%
Бүгд	187	100%	60	100%	800	100%

**Хүснэгт 2**

Оюутнуул эмч болох хүний зан төлөвийн үнэлгээгээр

Үнэлгээ	Шинжүүл	Олон төгөлдөр		Сэтгэл нь паган		Зорилго нь тод		Ажилдаа хичээнгүй		Овор нь талов	
		п	%	п	%	п	%	п	%	п	%
Үнэлгээ	Муу Дунд Сайн Бүгд	17 246 75 338	5,03 72,78 22,48 100	6 187 145 338	1,78 182 156 100	0 53,85 46,15 38	0 283 64 10	11 77,81 18,93 100	3,25 234 101 338	0,89 69,23 29,88 100	
Муу Дунд Сайн Бүгд	48 341 73 462	10,39 73,81 15,43 100	5 73 61,47 462	1,08 15,80 253 100	0 209 54,76 100	0 45,24 462	15 641 86 462	3,25 78,14 18,61 100	5 270 187 462	1,08 58,44 40,48 100	
Бүгд	65 587 148 800	8,13 73,38 18,50 100%	11 360 53 800	1,38 45 409 100	0 391 51,13 800	0 48,88 150 800	26 624 150 800	3,25 78,0 18,75 800	8 504 288 800	1,0 63,0 36,0 100%	

(хүснэгт 2) а) оюун төгөлдөр хэмээх үзүүлэлтээр бүх эмч болох хүний зан төлөвийн үнэлгээгээр авч үзвэл оюутны 18,5%, сайн 73,38% дунд зэрэг, 8,13% нь хангалтгүй гэсэн үнэлгээ авлаа. Оюун төгөлдөр байдлаар эрэгтэйчүүд (Сайн 22,19%, хангалтгүй 5,03%), эмэгтэйчүүдээс (сайн—15,8%, хангалтгүй—10,39%) давуутай байна. ( $P < 0,001$ ) б) цагаан сэтгэлтэй хэмээх үзүүлэлтээр оюутнуудын талаас илүү хувь нь (53,63%) сайн, 45% дунд зэрэг, 1,33% нь муу үнэлгээ авлаа. Цагаан сэтгэлээрээ эмэгтэйчүүд (сайн—61,47%), эрэгтэйчүүд (сайн—42,97%) мэдэгдэхүйц илүү байна.

Зорилго нь тод байдлаараа бүх оюутнуудын 51,13%—сайн, 48,48%—дунд, зэрэг байлаа. Хүйсний хувьд эмэгтэйчүүд (сайн 54,76%) эрэгтэйчүүдээс (сайн 46,15%) илүү байна.

Ажилдаа хичээнгүй байдлыг авч үзвэл бүх оюутны ихэнх хувь нь (78%) дунд зэрэг байгаа бөгөөд хүйснээс хамаарах ялгаа ажиглагдсангүй.

Овор нь төлөв байдлаараа оюутнуудын 36% сайн, 63% нь дунд зэрэг, зөвхөн 1% нь муу гэсэн үнэлгээ авчээ. Эмэгтэйчүүд (сайн—40,48%) эрэгтэйчүүдээс (сайн—29,88%) мэдэгдэхүйц давуу байна.

Дээр дурдсан судалгааны үр дунд үндэслэн дараах дүгнэлтийг хийлгээ.

АУИС-ийн элсэгчид, оюутнууд, төгсөгчдийг (тэргүүний) өөрслүүний боловсруулсан сэтгэц-физиологийн сорилоор харьцуулан судлахад ихээхэн бодитой үр дун гарсан нь өөрийн гэсэн өвөрмөц хувилбартай хүчин төгөлдөр сорил болсныг харууллаа. Энэхүү сорилоор эмнэлгийн сургуульд элсэгчдийг шилж сонгох, сургалтыг боловсронгуй болгох зорилгоор ашиглах бүрэн боломжтой гэж үзлээ.

## ХҮҮХДИЙН НҮДНИЙ ГЭМТЛИЙН ЗАРИМ АСУУДАЛД

АУ-ны доктор, профессор  
А. В. ХВАТОВА

АУ-ны дэд эрдэмтэн, доцент  
Э. САНЖАА

Хүүхдийн нүдний эмч, эчнээс  
аспирант М. ЭНХТУУЛ

Нүдний гэмтэл нь хүүхдийг тахир дутуу болгох үндсэн шалтгаануудын нэг болоод зогсохгүй гэмтсэн нүдний харааг эрс муутгаж улмаар сохиход ч хүргэдэг.

ЭНЭШТӨВИЙН нүдний тасагт 1987—1991 онд эмчлүүлсэн 2091 хүүхдийн 392 (18,75%) нь нүдний гэмтлээр анх-

дагчаар хэвтсэн байлаа. Эдгээрийн (48,47%) нь хөдөө орсон нутгаас ирж эмчлүүлжээ.

Хүүхдийн нүдний гэмтэл нь жилийн 4 улиралд харилцан адиlgүй тохиолдож байгаа бөгөөд 3—6 дугаар сард гэмтэл ихэсдэг нь дулааны улиралт эхлэхэд хүүхдүүд гадаатоглох нь ихсэж, тэдэнд тавих анхаарал сулардагтай холбоотой гэж үзэж бэлэх юм.

Бид хүүхдийн нүдний гэмтлийн нас, хүйсний байдалд судалгаа хийж үзэхэд нийг гэмтлийн 75,26 хувийт хөвгүүд, 24,74 хувийг охид эзэлж байна. Гэмтэл 3 хүртэлх насны хүүхдэд 64 (16,33%), 4—7 насанд 122 (31,12%), 8—11 насанд 94 (23,98%), 12—16 насанд 112 (28,57%) тохиолдож байна.

Нүдийг гэмтээж буй зүйлсийг судлаж үзэхэд ихэнх нь чавх, нум сум, мол, чулуу, төмөр утас, тэсэрч дэлбэрэх бодис (177 буюу 45,15%) ба хутга хайч, зүү зэрэг хурц зүйл 126 (32,4%) байна.

Нийт гэмтлийн 210 буюу 53,57% нь гадаа гудамжинд, 166 (42,35%) нь гэртээ, 16 (4,08%) нь хүүхдийн байгууллагад тохиолдож байна.

Хүүхдийн нүдний гэмтлийн дотор алимны нэвт гэмтэл 250 (63,8%), нүдний алимны битүү гэмтэл, доргилт 59 (15,0%), түлэгдэлт 24 (6,1%) нэвт биш гэмтэл 14 (3,6%), хамгаалах ба дайвар хэсгийн гэмтэл 45 (11,5%) байна.

Нэвт гэмтлийт байрлалаар нь ангилбал нэгдүгээрт эвэрлэгийн гэмтэл—169 (67,6%), хоёрдугаарт эвэрлэгсклерных —38 (15,2%), гуравдугаарт склерных—25 (10,0%) ба лимбийн байрлалтай гэмтэл 18 (7,2%) орж байна.

Нүдний гадна бурхүүлийн гэмтлийн хэмжээгээр авч үзээл 6 мм-ээс дээш шарх 40%-д нь тохиолдсон ба алимын бүрэн хамарсан том шарх 11 (4,4%) байлаа.

Нүдний нэвт гэмтлийн хүндрэл, явц, хүүхдийн ерөнхий биесийн байдлаас хамаарч бүйт харьцуулж үзэхэд нүдний идээт үрэвсэл, гэмтлийн иридоциклизт эрүүл хүүхдэд 17,3%-д нь, ямар нэгэн өвчтэй (шуд, хамар хоолойн архаг үрэвсэл, гэдэсний цагаан хорхойтой, харшилтай, хүүхдэд 44,9%-д нь тохиолдсон) байна.

Нүдний алим авах мэс засал хийсэн 26 хүүхдийн 11 (42,3%) нь алимын том хэмжээний гэмтэл (судаслаг болон шилэнцрээ алдсан) 10 (38,5%) нь панофтальмит, 4 (15,4%) нь нүдний хатангиршил, 1 (3,8%) нь симпатик үрэвслээс шалтгаалжээ.

Нүдний алимын битүү гэмтэл, доргилттой 59 хүүхдээс 4 (6,8%) нь хөнгөн, 31 (52,5%) нь дунд зэргийн, 24 (40,7%) нь хүнд гэмтэл байлаа. Дундаж ор хоног 15,8. Энуклеац

хийгдээгүй.

Нүдний тулэгдэлтэй 24 хүүхдээс халуун зүйлд тулэгдсэн 15 (62,5%), хиймийн бодисоор тулэгдсэн 9 (37,5%) байсан. Нэгдүгээр зэргийн тулэгдэлт 6 (25%), хоёрдугаар зэргийнх 16 (66,7%) гуравдугаар зэргийнх 2 (8,3%) тохиолдож, дөрөвдүгээр зэргийн тулэгдэлт тохиолдоогүй, Дундаж ор хоног 9,7. Энуклеац хийгдээгүй. Эмнэлгээс гарах уедээ 79,2% (19) нь 0,7—1,0 хараатай, 16,6% (4) нь 0,4—0,7 хараатай байсан. Зөвхөн 1 (3,8%) хүүхэд эвэрлэг уул үлдсэнээс 0,3 хараатай эмнэлгээс гарсан байна.

### Дүгнэлт

Манай оронд тохиолдож байгаа хүүхдийн нүдний гэмтлийн дийлэнх хувийг хүнд гэмтэл эзэлж байгаа нь нүдний эмч бидний анхаарлыг зүй ёсоор татаж, гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлыг идэвхтэй явуулж, нүдний гэмтэлд үзүүлэх тусlamжийг зөв зохион байгуулан эмчилээний аргуудыг улам боловсронгуй болгож, мэс заслын өвөрмөц багаж төхөөрөмжөөр хантах нь чухал байна. Мөн хүүхдийн шуд, хамар хоолой, цагаан хорхойтох, харшлын зэрэг өвчинийг эрт илрүүлж эмчлэх нь чухал байна.

### НАСАНД ХҮРЭГЧДИЙН ГЭНЭТ НАС БАРСАН ТОХИЛДЛУУДАД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ДҮНГЭЭС

Дэд эрдэмтэн Д. Амгаланбаатар Дэд эрдэмтэн С. Тамжидмаа УШЭМТ

С. Түндэврэнцэн багш  
(Улсын шүүх эмнэлгийн  
1980—1989 онуудын материалаас)

Орчин үеийн əнагаах ухааны тулгамдсан асуудлуудын дотор зүрх судасны, ялангуяа зурхний шигдээс (титэм судасны дутмагшил ДЭХ 1971 он) өвчин ихсэж байгаа нь онөө үеийн олон орны эмч, эрдэмтдийн сэтгэлийг ихэд түгшээх боллоо.

Зүрх судасны гаралтай өвчинөөр нас барагсадын 58%-ийг зүрхний шигдээс эзэлж байна. (ДЭХ 1985 он)

Европ ба Америкийн үйлдвэржсэн оронд жилд 100 мянган хүнд 20—60 насны эрэгтэйчүүд ойролцоогоор 19—159 тохиолдоор гэнэт нас барж байна.

Зүрх судасны өвчинөөр гэнэт нас барсан тохиодлын 60%-д нь титэм судас ихээхэн гэмтэж байна. (Ф. Ренго бусад) Америкт жилд 1200 тохиолдолд гэнэт нас барсны

дотор зүрхний гаралтай нас баралт 25%-ийг эзэлж байна.

Хөдөлмөрийн хүмүүс эрүүл юм шиг гэр орондоо юм уу ажлын талбарт гэнэт нас барах тохиолдлууд нь сүүлийн үед ажиглагдах боллоо. Улсын Шүүх Эмнэлгийн Магадлах Товчооны сүүлийн 10 жилийн материалаас узэхэд нас баралтын 16,9%-ийг гэнэт нас баралт эзэлж байгаагийн 32,4% нь зүрхний шигдээсээр (титэм судасны дутаагдал) 12,7% нь тархинд цус харваж, үлдсэн нь бусад шалтгаануудаар нас баржээ. Зүрхний титэм судасны хурц ба архаг дутагдлаар нас брагсадын: 36,2% нь гэртээ, 24,9% нь гудамжинд, 13,3% нь ажил дээрээ хөдөлмөр эрхэлж байхдаа, 25,6% нь бусад нөхцөлд нас барсан байна. Дээрх баримтаас гэртээ нас баралт их байгаагийн учир шалтгааныг тодруулж үзэхэд гэр ахуй тох тухгүй байдал, амьдралын аар саархан зүйлээс болж маргалдах, сэтгэл зүйн хямралт байдал нэлөөлсөн байж болох талтай юм.

Манай оронд нас баралт 4,5, 6-дугаар саруудад ихээхэн Тохиолдож байна. Мөн нас хүйсээр нь нягталж үзэхэд эрэгтэй 83,2%, эмэгтэй 16,8%, 19—27 насных 5,4%, 30—39 насных 13,6% 40—49 насных 23,3%, 50—59 насных 26,0%, 60—69 насных 17,0%, 70-аас дээш насных 15,7%-ийг тус тус эзэлж, өөрөөр хэлбэл бүх тохиодлын 50 орчим хувь нь 40—60 насны хүмүүс эзэлж байна.

Шигдээсийн байрлал, явцыг авч үзэхэд зүрхний ачаалал ихтэй хэсэг болох зүүн ховдлын шигдээс 98,5%-ийг эзэлж байгаагийн зэрэгцээ зүрхний архагт хэлбэрийн шидээс 75,0%-ийг, хурц хэлбэр 24,2% байна. Судалгаагаар титэм судасны хатуурах түүнээс өгөх өөрчлөлт гол хувийг эзэлж байгаагаас эл бүхэн зүрхний цусан хангамж, титэм судас түүний онцлог байдлыг судалж үзэх нь онц чухал юм.

Дэлхийн олон орцнд эмч эрдэмтэд зүрхний эмгэгийт титэм судасны рентген-анатомийн талаас судалж, онцлохыг чухалд үздэг бөгөөд энэ талаар одоогоор манайд доржитой хийсэн ажил угүй, байгаа бөгөөд Монгол хүний зүрхний эрүүл эмгэг үеийн цусан хангамжийг түүний онцлогтой холбож судлах нь зүрхний эмгэг өвчинүүдийг онцлох, зүрх судасны мэс ажилбар, тэр тусмaga титэм судасны мэс ажилбар хийх, шинжилгээний арга (корюнографийн) тус орцанд амжилттай хөгжүүлэх нэг чухал нөхцөл юм.

## ЭЛЭГНИЙ ЭД ЭСИЙГ ШИНЖЛЭХ АРГАЧЛАЛ

Б. Нацагдорж, Б. Дагвадорж,  
Я. Дагвадорж АУИС

Өнөөгийн анагаах ухааны хөгжлийн зүй тогтлын дагуу эмгэг өөрчлөлтийг эд эсийн бүтцийн түвшинд тогтооход биопси шинжилгээний арга ондөр ач холбогдолтой.

Элэгний биопсийн шинжилгээ (ЭБШ) элэг судаллын өдөр тутмын ажиллагаанд байнга хэрэглэгддэг чухал шиншилтээнүүдийн нэг юм. Элэгний эмгэгүүдийг клиник сэтгэлгээгээрээ хэрхэн оношлосоноо батлах, оношийт төгс нотлох, өвчний явц үе шатыг тогтоох, эмчилгээг зөв шийдвэрлэхэд ЭБШ олон талын ашигтай. Одоогоос 150 гаруй жилийн тэртээ Биэтт, Стакле нар элгэнд хатгалт хийснээр шинжилгээний энэ аргын үндэслэл гарсан түүхтэй. Р. Иверсен, К. Рохолм нар 1939 онд гусгай зүү санаачлан хийж элэгний эд эсээс шинжилгээ авах болсоноор элэг судаллын практикт өргөн хэрэглэх болжээ.

Манай оронд энэ аргыг 1970 оны сүүл үеэс Улсын Клиникийн Төв эмнэлгийн Гастроэнтерологийн тасагт (Б. Дагвадорж, Я. Нина нар) хэрэглэж эхэлсэн боловч нийт эмнэлгийн үйл ажиллагаанд тогтмолжиж чадаагүй байна. Энэ нь нэг талаас эмч нар клиник сэтгэлгээ лабораторийн шинжилгээнд түшиглэн оношлодог уламжлалт аргад «хэт» дадсан, уг шинжилгээг хийх эрмэлзэлтэй эмч, мэргэжилтэн цөөн, элэгний архаг өвчтэй хүмүүсийн диспансерийн хяналт хангалтгүй, нөгөө талаас шинжилгээ хийх тариур, зүүний хүртээмжгүй клиник-морфолог эмч нарын ажлын нягт уяддаа байнгын биш, элэг судаллын эрдэм шинжилээний нэгдсэн төвгүй учир судалгаа, шинжилгээний ажил хоцрогдож байгаатай холбоотой.

Судлагч Н. Роррег (1965), Х. Х. Мансуров, Д. Г. Рулоj (1962) нар ЭБШ 71,8—96 хувьд оношийт батлах, тодотгох, шинээр оношлох ач холбогдолтой болохыг нотолсон.

### ЭБШ зорилго

1. Элэгний цочмог, архаг үрэвслүүдийг ялган оношлох.
2. Элэгний өвчинүүдийн шалтгаан, эмгэг жамыг илрүүлэх.
3. Элэгний өвчинүүдийн үе шатыг зөв тогтоох.
4. Элэг анхдагчаар үрэвссэн эсвэл өөр өвчиний улмаас эмгэгшсэн бүтцийн өөрчлөлтийг нотлох.
5. Элэгний дистрофи өөрчлөлтийг тогтоох.
6. Эмнэл зүйн шинж, биохимийн узуулэлтийг эд эсийн бүтцийн өөрчлөлттэй холбон судлах

7. Өвчний явц, тавилан, хүндрэлийг тогтоох.
8. Өвчтөнд эмчилгээ хийх, түүний үр дүн, урьдчилан сэргийлэлтийг шийдэх.

Элэгний эдээс дээж авахдаа дараах З аргыг хэрэглэдэг

1. Мэс заслын замаар буюу нээлттэй арга.

2. Хэвллийг цоолж дурандах замаар.

3. Биеийн гаднаас элэг руу хатгаж шинжилгээ авах.

Хэвллийн эрхтэнд мэс засал хийх үед нээлттэй аргаар элэгнээс дээж авна. Төрчлөлттэй хэсгээс нүдээрээ харж, элэгнээс эд авах боломжтойгоороо сайн талтай боловч элэгний зөвхөн доод хэсгээс шинжилгээнд авдаг учир эмтэгтэй хэсгээ олоогүй, мэдээ алдуулагч бодис, мэс засалчийн гарг элэг гэмтэж болзошгүй тул энэ аргыг өргөн хэрэглэдэггүй.

Хоёрдугаар арга нь эхнийхийг бодоход өргөн хэрэглэж болох боловч өвчтөнд шаналгаа ихтэй, тодорхой хэмжээний цаг хугацаа мэс заслын байр, гэрэлтүүлэгч ба-гаж хэрэгсэл шаардлагаас хязгаарлагдмал хэрэглэдэг. Хэвллийн зарим өвчнийг ердийн шинжилгээний аргаар оношлох боломжгүй нөхцөлд заалтын дагуу хэвллийг цоолж дурандах арга хэрэглэх ба энэ үедээ элэгний харагдах хэсгээс эдийн шинжилгээ авдаг.

Биеийн гаднаас элэг руу хатгаж шинжилгээ авах арга нь олон сайн талтай учраас энэ талаар арай дэлтэрэнгүй өгүүльье. Энэ арга нь цаг хугацаа бага шаарддаг өвчтөнд шаналгаа багатай, хүндрэл цөөн илэрдэг давуу талтай учир дэлхий нийтэд өргөн хэрэглэж байна.

Хатгалтаар шинжилгээ авахдаа Вим Сильверманы зүү болон Менгины тариур, зүүг ашигладаг. Вим Сильверманы зүү нь элэгнээс жижиг хэсгийг зүсэж шинжилгээнд хүрэлцэхүйц эд авчирдагаараа сайн талтай боловч цус алдуулж болзошгүй гаж нөлөөтэй!

Менгины тариур зүү нь элэгний эд эсээс соруулж авахад үндэслэсэн бөгөөд шинжилгээнд хүрэлцэхүйц эд эсийг авчирдаг. өвчтөнд шаналгаа багатай хүндрэл бараг илэрдэггүй, шинжлэгч уг үйлдэлд түргэн дадаж туршилагажих бололцоотой, ариутгаж цэвэрлэхэд хялбар зэрэг сайн та-луудтай.

### ЭБШ хийхэд шаардагдах зүйлс

1. Менгины тариур, зүү эсвэл Вим Сильверманы зүү
2. Арьс цоолох жижиг хутга, цоолуур
3. 10 мл-ийн тариур, 2 зүүний хамт
4. 76-спирт, иодын ханд 10,0—15 мл
5. Новокаины 0,25% 0,5%-н ариун уусмал 10,0—20 мл

6. Шархны лент
7. Ариутгасан самбай, хөвөн бөмбий
8. Цэвэр тавиур, сав
9. Физиологийн ариун уусмал 10,0—20 мл
10. Шинжилгээнд авсан эд хийж бэхжүүлэх уусмал (формалины 10%-ийн уусмал 10 мл),
11. Өвчин намдаах, цус тогтоож тарилгууд.

#### **Менгины тариур, зүүгээр элгэнд хатгалт хийх зөвлөмж**

Шинжилүүлэгчийг тусгай өрөөнд модон орон дээр хэвтүүлэн судсыг тоолж, артерийн даралтыг хэмжих хэрэгтэй. Зүүн хажуугаар нь хэвтүүлэн зүүн гарыг нь дэрлүүлээд сувзэн дор нь тусгай ивээс эсвэл хөнжлийн дээд хэсгээс чанга хуялаад ивэж болно. Ингэж хэвтүүлэхэд хатгалт хийхэд хялбар болдог. Хатгалт хийхийн өмнө элтний доод хязгаарыг тэмтрэх, тогших аргаар сайн тогтооно.

Элэгний хатгалтыг баруун суганы урд, дунд шугамаар 9, 10-р хавирганы завсраар хийх нь тохиромжтой. Элгэнд хатгалт хийх цэг нь элэгний том, бага, тухайн хүний мах мариа, голомтот өөрчлөлтийн байрлалаас хамаарах боловч судасны тогтолцоо, элэг рүү орох боломжийг харгалzan баруун суганы дунд шугамаар хийх нь илүү тохиромжтой байдаг. Элэг нь их томорсон уед өвчтөнөө гэдрэг нь харуулан хэвтүүлж голын шугамаар хатгалт хийж болно.

Шинжилгээ хийхийн өмнө өвчтөний тайван байдлыг бүрэн хангах ёстой. Бэлтгэлийг бүрэн хангасаны дараа эмч гарaa угааж ариутгаад дээрх шугамаар 9 ба 10 дугаар хавиргатай огтлолцсон цэгийг хатгалт хийх төв болгон төвлөж идоор чагт тавин тэмдэглэж уул таалбайг спирт-идоор ариутгана. Ариутгасаны дараа новоканины 0,25—0,5 хувийн уусмалаар үечлэн мэдээгүйжүүлээд хурц, нарийн үзүүртэй цоолуураар (скальпел, ланцет) арьс, өөхөн эд булчинг цоолно. Энэ нүхээрээ 10 мл физиологийн уусмал соруулсан зориулалтын зүүтэй тариурынхаа зүүг чиглүүлэн зөөлөн явуулж хэвллийн гялтан хальсанд хүргэх бөгөөд зүүний үзүүр хүрч байгаа нь өвчтөнд мэдрэгдэнэ. Энэ уед зүүн гартаа тариураа шилжүүлэн баруун гараараа огцом түүхэн гялтанг цоолно. Энэ нь өвчтөнд хүчтэй цочирч мэдэгдэнэ. Гэхдээ зүүг цааш гүн хатгаж болохгүй. Учир нь гялтангийн дор байгаа элэгний бүрхүүл, түүний эд хатгагдан цус хурж хүндрэл үүсч болно. Гялтанг цоёлсод 5 мл орчим уусмал шахан зүүний нүхийг чөлөөлж улмаар шахуургыг буцааж татаан бага зэрэг эргүүлэн хоногт оруулан бэхэлж тариур дотор сөрөг даралт үүсгэсэний дараа өвчтөний амьсгалыг гаргуулан түгжүүлээд зүүн гараараа бэ-

хэлж, баруун тараараа элэг рүү огцом түлхэлтээр хатган тариураа зүүний хамт сугалан авч сорогдож ирсэн эд эсийт бэхжүүлэх уусмалтай шилэнд хийж шинжилгээнд илгээнэ. Зүүг элэг рүү 3—3,5 см хиртэй гүн хатгаж шинжилгээ авна. Хатгалт хийсэн нүүхийг цэвэр самбай бөмбийгөөр дарж шархны туузаар бэхлэнэ. Өвчтөнг зөөврийн тэргээр орон дээр нь хүргэн 2-цагаас доошгүй хэвтүүлж судасны лутшилт, артерийн даралтыг тогтмол шалган эмчлэгч эмч болон жижүүрийн эмч, сувилагчийн хяналтад энэ өдөртөө байлгах хэрэгтэй. Цус алдалтын шинж илэрвэл цус тогтоох яаралтай арга хэмжээ авна.

### ЭБШ хийх бэлтгэл

1. Шинжлүүлэгчид шинжилгээний ач холбогдолыг сайтар ойлгуулна.
2. Сэтгэл санааны бэлтгэл сайн хийж шаардлагатай хүмүүст тайвшрууллах ба нойрсуулах эм 1—2 хоног өгнө.
3. Цусны дэлгэрэнгүй шинжилгээ хийхийн зэрэгцээ цус бүлэгнэлт, урсах хугацаа, тромбоцит, протромбины хэмжээг тодорхойлно.
4. Хэвлэлийн болон цээжний эрхтэнг рентгенд харж өрцний байрлал зайд, цээжний хөндийд шингэн хуралдсан эсэхийг шалгана.
5. Хэрэв цус гоожимтгой, цусны бүлэгнэлт уртассан, тромбоцитын тоо цөөн байвал 5—7 хоног цус тогтоох эмийн засал хийх хэрэгтэй.
6. Хэвлэлийн шингэн ихтэй бол хатгалт хийхийн өмнө шингэнг авч элэгний дээд доод хязгаарыг тэмтрэх, тогших аргаар тодорхойлно.
7. Шинжилгээг станционарын нөхцөлд хийх нь зүйтэй.
8. Шинжилгээний өмнөх орой өвчтөн хөнгөн хооллох ба өглөө нь өлөн байна.

### ЭБШ хийх заалтууд

1. Шалтгаан нь мэдэгдэхгүйгээр элэг, дэлүү томрох.
  2. Эмнэлзүйн тодорхой илрэлгүй мөртлөө үйл ажиллагааны сорилууд өөрчлөлттэй байх.
  3. Элэгний архаг үрэвсэл, сорвижлын шалтгаан, идэвхжил тодорхойгүй үед.
  4. Шалтгаан нь тодорхойгүй шарлалтууд
  5. Бодисын солилцооны өөрчлөлтөөс элэг эмгэгшсэнийг оношлох (элэг зэсжих, төмөржих, гаж уурагжих гэх мэт)
- Элгэнд хатгалт хийж болохгүй заалтууд
1. Цус бүлэгнэлт удаашралтай, цус гоожимтгой хүмүүс.
  2. Цусны өвчнүүд
  3. Цус багассан хүмүүс
  4. Цусны даралт ихдэх өвчиний З-р үе

5. Элэгний бэтэг, буглааны үед
6. Зурхний гажгууд, цусны эргэлтийн дутагдлын хүнд  
үе
7. Зүрх, судасны хүрц дутагдал
8. Цусан үжил өвчин
9. Элэгний аяндагч өмөнгийн II зэргээс дээш үе
10. Цөсний суваг, хүүдийн идээт үрэвсэл
11. Удаан хугацаагаар үргэлилсэн шарлэх шалж ё.  
хий хумүүс
12. Ухаангуй өвчтөн
13. Элэгний цочмог ба архаг дутагдэл, комши үрт
14. Өвчтөний биеийн байдал хүнд, сэтгэл санаа нь тай-  
ван бус тохиолдолд
15. Дэмийрч салиорсон өвчлөн.

### **ЭБШ хийх үед илэрч болох хүндрэлүүд**

1. Хатгалт хийсэн орчим, аюулхай, баруун мөр, эгэм рүү дамжин өвдөж болдог. Энэ нь өвчтөний сэтгэл санаа хямарсан, хавирга хоорондын мэдрэл цочирч гэмтсэнтэй холбоотой боловч өвчин намдаах эм тарилганд амархан намдана.

2. Элэгний бүрхүүл дор, хэвлэй цээжний хөндий рүү цус алдах. Гол шалтгаан нь элэгний захад байрлалтай өргөссөн судас, судасны болсн хоргүй хавдар, бэтэгний цэв-  
рүүг гэмтээдэг.

3. Хэвлэй цээжний хөндийд идээт үрэвсэл үүсэх. Энэ хүндрэл ховор тохиолдог боловч элэгний буглаа эсвэл цээжний хөндий рүү хатгаж уушгийг гэмтээн халдварт ор-  
сонтой холбоотой. Мөн цөсний ургсал saatсан, идээлж үрэвсэн үед тохиолддог.

4. Цээжний хөндийд хий хуралдах. Энэ нь элэгний хил хязгаарыг буруу тодорхойлж уушги руу хатгасанаас үүсдэг.

5. Цөсний өргөссөн суваг, хүүдий хатгагдаж хэвлэйн хөндийд цөс гоожин гялтан хальсны үрэвсэл үүсч болно.

6. Арьсан доор хий, цус хурж болно.

7. Судасны сулрал болж артерийн даралт буурах.

8. Рефлексээр гэдэсний хөдөлгөөн саажиж болдог.

Болгоомжтой няхуур нямбай хийвэл ийм хүндрэл то-  
хиолдохгүй.

Бид Мэнгинь тариур зүүгээр 75 том хүн, 13 хүүхдэд шинжилгээ хийхэд ямар нэгэн хүндрэл ажиглагдаагүй. 72 тохиолдолд эмнэлзүйн онош тохиорон б тохиолдолд онош өөрчлөгдсөн болно.

Хатгалт хийх үед элэгний эд нилээд саадтай байвал элэгний сорвижилт байх бөгөөд авсан эд голчлон хэсэгчилсэн тогтошгой зүүнээс шахаж гаргахад бутарч салдаг. Хатгахад бутарч салдаг. Хатгахад саалтай буюу жирийн хатгалтаар элэг рүү нэвтэрч орохгүй байвал элэгний бүрхүүл сорвижин хатуурсан байдаг. Зүү хөнгөн сүл орвол голдоо задралтай хавдрын голюомт эсвэл буглаа, бэтэг, усан ба цусан хавдар болохыг заана.

Элгэн дэх цэсний зам түгжирсэн үед эд ногоон өнгөтэй, цус багатай, өөхөлсөн үед цайвар, хул шар, бичил элементийн өөрчлөлтийн үед зэгэл саарал, хүрэл зэс шиг өнгөтэй байдаг.

#### Авсан эдийг шинжилгээнд бэлтгэх арга:

Дээж эдийг эд эсийн шинжилгээнд зориулан бэхжүүлдэг гол уусмал бол 8—10%-ийн саармагжуулсан формалин бөгөөд зарим эмтэг өөрчлөлтийн шалтгаан, гарал үүслийн нарийвчлан үзэхэд тусгай зориулалтын уусмал хэрэглэх шаардлагатай байдаг тул урьдчилан эмгэг судлаач эмчтэй тохиролцож бэлдүүлэх хэрэгтэй. Жишээлбэл: Энзимогистохимиийн болон профиринийг тодорхойлоход бэхжүүлэх уусмал хэрэглэдэггүй, гликоген ба мукополисахаридийг тодорхойлоход спиртэд бэхжүүлдэг гэх мэт.

Бэхжүүлсэн эдийг цаазшид лааны тосонд цутгаж 4—6 микрон зузаантай зүсэж будаж бэлдэнэ.

Эд эсийн будах аргууд:

Өдөр тутмын түгээмэл арга болох эсийн сийвен, бөөмийн тогтолцоог дүгнэхэд гемотоксин-эозин, уян ширхэгийн илрүүлэхэд мөнгөлөх, холбох эдийн ширхэгийг будахад Ван-гизон болон Малорын аргын хувилбарыг, төрөл бүрийн нөсөөг ялган үзэхэд Перлсийн аргыг тус тус хэрэглэнэ.

Будгийн зарим нэг тусгай аргуудаас товч сийрүүлбэл;

1. Элэгний эсийн өөржилт буюу гликолипидийн нэгдлийг суданы төрлийн судан—3, судан—4, хар судан, шарлах-улаан зэрэг будгаар хөлдөөнөн зүсмэгт мөн шиффийн аргаар туйлшуулагч микроскопийн тусламжтайгаар илрүүлнэ.

2. Гликоген ба саармаг мукополисахаридийг илрүүлэхэд Бестийн арга ба ШИК (Шифф-периоднаяниолота)-ийн урвалыг хэрэглэнэ.

Хүчиллэг мукополисахаридийг өнгө хувиргагч толуидин-хөх, метил-хөх, азур-А зэрэг будгуудыг хэрэглэнэ.

3. Амин хүчил-ДНК (дезоксирибонуклейний хүчил)-ийг фелгиний аргаар ,РНК (рибонуклейний хүчил)-ийг Шабадашийн аргаар, энэ хоёр хүчлийг зэрэг тодорхойлох бол Брашегийн аргыг тус тус хэрэглэнэ.

4. Амилоидийт конго-рот, хөх ягаан крезил зэрэг будгийн аргаар илрүүлнэ.

5. Нөсөө нь янз янз байх ба тухайлбал дотор ба гаднын гаралтай гэж антилагдаха. Бие махбодийн дотсод шалтгаантай үүссэн нөсөө нь өвчин эмгэгшилийг ялан оношлоход чухал нөлөөтэй бөгөөд голдуу уургийн гаралтай байна. Алтлаг шарталдуу үүрмэг мөхлөг лиофусцинийг Шифф ба Шморлийн араар тодорхойлно.

Төмрийн нэгдлийг агуулдаг ферритин гэдэгнөсөө нь ли-псфусцинийг бодвол харьцангуй их биш байна, голдуу хэсгэнцэрийн захын эсэд агуулагддаг. Төмрийн нэгдлийг Перлсийн аргаар илрүүлнэ.

Вируст гепатитийн антигенийг орсейн, альдегид фуксин, альдегид, тионин зэрэг будгуудаар илрүүлнэ. Гэхдээ гадаргуугийн ба төвийн антигений илрэх байдал, байрлал нь өөр өөр учир хэрэглэх арга өөр өөр байна. Орсейнээр будах нь хамгийн хялбар арга бөгөөд бараан хүрэн өнгөөр будагдах учир лиофусцин, липид, цөсний нөсөө, төмөр, альф-антитрипсин зэргээс ялгах хэрэгтэй.

Элэгний биопсийн дүгнэлт үнэн бодит болоход дээж материал аль болох хүрэлцээтэй, эдийн шинжилгээний бэлдмэлийн арга нь зөв байх шаардлагатай. Эд эсийн шинжилгээний зөв дүгнэлт гаргахад наад зах нь нэгээс доошгүй хэсгэнцэр авагдсан байх хэрэгтэй бөгөөд тиймгүйгээр хэсгэнцэрийн тогтолцоо, эдгээрийн хоорондох таславч, судас ба цөсний сувганцрын байдлыг дүгнэх бололцоогүй байдаг. Эдгээрийн талаархи дэлгэрэнгүй бичлэг нь эмчлэгч эмчид чухал хэрэгтэй бөгөөд түүнийт харгалзан эмнэл зүйн явц, эмчилгээний үр дүн, тактикийг тооцоолох ёстой. Эмчлэгч, эмч, эмнэлзүйн ба биохимийн шинжилгээний талаар илгээмждээ дэлгэрэнгүй бичиж зарим анхаарах зүйлсийн талаар эмтэг-биезүйчдэд хандан жич цохон тэмдэглэж бичих хэрэгтэй. Морфолог эмч тодорхой тохиллолд хариуг яг онош маягаар харнуулж болох боловч ихэнх тохиолдолд ямар чиглэлийн өөрчлөлт байх нь илүү боломжтойг дэлгэрэнгүй бичлэг дүгнэлтээр хариулах нь илүү тохиромжтой.

Бидний энэ зөвлөмжийг өдөр тутмын үйл ажиллагаанд даа хэрэглэж санал бодлюу өргөн ирүүлнэ гэдэгт итгэж байна.

## ҮЙЛ ЯВДАЛ

### ЗҮҮН ӨМНӨТ АЗИЙН БҮСИЙН ЗӨВЛӨГӨӨН

Анагаах ухааны боловсролын чиг баримжааны асуудлаар ДЭМБ-ын Зүүн Өмнөт Азийн Бүсийн гишүүн орнуудын 4 дэх удаагийн зөвлөгөөн БН Энэтхэг улсын нийслэл Шинэ Дели хотод саяхан болж өнгөрөв.

Зөвлөгөөнд БН Энэтхэг, Шриланка, Бангладеш, Тайланд, Индонез, Непал, Мианмар, Монгол, Солонгос зэрэг гишүүн орнуудын болон ДЭМБ-ын Женем дэх төв, Дэлхийн банкны төлөөлөгчид оролцлоо.

Түрүүчийн зөвлөгөөнээс хойши улс орон бүрийн болон бүсийн хэмжээнд хийсэн ажлыг хэлэлцэн дүгнэж, анагаах ухааны боловсролын асуудлаар цаашид баримтлах чиг боллогыг боловсруулав. Зөвлөгөөнөөр зөвхөн анагаах ухааны боловсролын асуудал яриад зогсоогүй, түүнтэй холбоотой асуудлууд, тухайлбал боловсон хүчиний хангамжийн асуудлаар илтгэл тавигдас. Бүсийн гишүүн орнуудаас Солонгос, Монгол улс эмчийн хангамжаар хүрэлцээтэй (10,000 хүн амд 27 их эмч ногдоно) бусад гишүүн орнуудад эмч хүрэлцээгүй буюу хүрэлцээ муутай гэж тэмдэглэв.

Жишээ нь Нецалд 10000 хүн амд 0,5, Энэтхэгт 4,4 их эмч ногдож байна. Харин манай улс 6122 их эмч 18731 эмчилгийн дунд мэргэжилтэн байгаа нь хамгийн зохижтой харьшaa (1:3) гэж ДЭМБ узжээ.

ДЭМБ-аас анагаах ухааны боловсролны удирдлагын агуулдлыг бие даасан мэргэжил гэж узэж тусгай сургалт явуулдаг бөгөөд гишүүн орнуудад урт богино хугацаагаар өөрийн зөвлөхийг ажиллуулж анагаах ухааны боловсролыг тогтолцсог хөгжүүлэхэд нь их хүч чармайлт гарпаж лэмжлэг тусалцаа узуулж байна. Тухайлбал, одоо Бангладеш, Непал, Мианмар зэрэг орнуудад тусгай зөвлөх ажилладаг юм байна. Зөвлөгөөний үеэр Бүсийн хорооны боловсон хүчиний асуудал хариуцсан дэд зэхирал Аунг-Тан-Бату, бүсийн хорооны сувилагчийн асуудал хариуцсан зөвлөх Салли Виш, анагаах ухааны боловсролын асуудал хариуцсан Палита Абекуун нартай албан ёсоор уулзаж ярилцлаа.

Цаашид эрүүл мэндийн салбарын боловсон хүчиний сургалтын чанарыг дээшлүүлэхийн тулд анагаах ухааны боловсролын сургалтын чиг баримжааг шинэчлэх нийтмийн хэрэгцээнд тулгуурлагдсан анагаах ухааны боловсрол эзэмшиүүлэх чиглэлээр сүүлийн 2 жилд авч хэрэгжүүлсэн арга хэмжээг бататгах, анагаах ухааны боловсролын удирдлаг-

гын зохион байгуулалтыг оновчтой болгох, анагаах ухааны боловсролын бодлогыг үндэсний нийгэм-эдийн засгийн хөгжлийн, боловсролын, үндэсний эрүүл мэндийн, эмнэлгийн тусламжийн бодлоготой уялдуулан улам боловсронгуй болгох нь чухал болоод байна гэж тэмдэглэв.

### Г. Цэцэгдарь

## СЭТГҮҮЛИЙН ДУГААРТ ОРСОН ӨГҮҮЛЛҮҮДИЙН АШИГЛАСАН ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ

А. Өлзийхутга, Ц. Алтанцавч

1. А. М. Вихерт, В. С. Жданов, Е. Е. Матева, С. Г. Алтекарь «Географическая патология атеросклероза» 1981 г
2. Эллиот Б. Ньюмен, Оглебм Пол, Сидни Блюментель «Атеросклероз» 1975 г
- 3.. Лувсанноров (канд. диссертация) 1970 УБ
4. Монгол улсын үндэсний атлас 1990 г
5. Галцог (Канд. диссертаци) 1975 УБ
6. Но. Дондог (канд. диссертаци) 1967 г. Москва
7. Г. Дэжээхүү (канд диссе) 1985 г. УБ
8. М. А. Самсонов нар 1971. Журнал «Питание» №6.
2. Д. Амгаланбаатар, Б. Дагданбазар
1. Я. Л. Караганов, В. Н. Кердиваренко, В. Н. Левин Атлас «Микроangiология» Кишинев «Штицица» 1952
2. В. В. Куприяновъ со автр. «Микролимфология» М. Медицина 1983
3. А. Е. Романовский «Тучные клетки и русло микроциркуляции после парасимпатической денервации» вкн: Проблемы функциональной лимфологии. 1882 г. стр 163—165
4. Н. Н. Чевагина Морфометрическая характеристика лимфатических узлов после повреждения симпатической иннервации. В. кн. Проблемы функциональной лимфологии 1982 г. стр 204—206
5. Электронно-микроскопическая анатомия перевод с английского Москва. Мир. 1967.
3. Ц. Лхагвасүрэн,
1. Алещин Б. В, Губский В. И. Гипоталамус и щитовидная железа М. 1983 г. С. 47—69
2. Жуковский М. А. Детская эндокринология Медицина. М. 1982 с. 275—295
3. Қабацый Н. П. Особенности состояния Т—и В—систем иммунитета и некоторые аутоагрессии при ДТЗ. Канд. дисс, М. 1985 г.

4. Касаткина Э. П., Соколовская В. Н. Гиперплазия щитовидной железы у подростков: патогенез и лечение. Пробл. эндокринол. 1988 г. №2 с. 32—42
5. Линденбратен Л. Д., Лясс Ф. М. Медицинская радиология. «Медицина» М. 1986 г. с. 122—139
6. Раскин А. М. Автоиммунные процессы в патологии щитовидной железы. Л. 1973 г. с. 24—29
7. Ром-Бугославская Е. С., Гальчинская В. Ю., Лилле Ю. Э. Взаимодействие тиреотропного гормона и простагландинов I<sub>2</sub> с рецепторами и их влияние на уровень ЦАМФ в ткани щитовидной железы человека. Пробл. эндокринол. 1987 г. №1 с 32—32
8. Сехнашвили З. Ш. Иммунологическая характеристика больных диффузным токсическим зобом. Пробл. Эндокригол. 1988 г. №2 с. 3—5
9. Труакулов Я. Х. Обмен йода и тиреоидные гормоны в норме и при патологии. Пробл. эндокринол. 1986 г. №5 с. 78—83
10. Утевский А. Ма., Чуйко В. А., Карпенко Л. Г. Захват  $I^{125}$  трийодтиреонина щитовидной железы: влияние адренергических веществ и низких температур. Пробл. эндокринол. 1985 г. №1 с. 77—81
11. Фабри З. П., Пащенко А. Е. Тиреоидная функция у лиц с гиперплазией щитовидной железы в условиях йодной недостаточности. Пробл. эндокринол. 1987 г. №2 с 33—36

Д Баасанжав, Г. Долгор

1. Бойко Ю. Г., Силаева Н. Н., Прокопчик Н. И. —К эпидемиологии сосудистых поражений головного мозга. Журн. невропат. и психиатр., 1976. №1. с 11—16.
2. Бурцев Е. М. —О роли генетических и средовых факторов в происхождении нарушений мозгового кровообращения у молодых людей. Журн. невропат. и психиатр. 1977. №3. с. 339—343.
3. Смирнов В. Е.—Распространенность сосудистых заболеваний головного мозга и значение некоторых факторов риска. Автореф. докт. дисс. 1978.
4. Канарейкин К. Ф., Бахур В. Т., Манвелов Л. С.—Алкоголь и курение как факторы риска мозгового инсульта. Журн. клинич. медицина 1987 №1 с 17—22
5. Неретин В. Я., Кирьянов В. А., Котов С. В. и др. —О влиянии алкоголя на мозговую гемодинамику. Журн. совет. медицина, 1987. №5. с 61—62.
6. Гачев О. Г. —Факторы риска в программе профилактики мозговых инсультов. Журн. совет здравоохран. 1987 №6, с 31—36,

6. И. Пүрэвдорж,

1. Гладкова Т. Д. Кожные узоры киста и стоны обеяния и человека М, 1966. 138 стр.
  2. Б. Баярсайхан. Монголчуудын гарын хээг судлах асуудалд Дипломын ажил 1992
  3. Намсрайнайдан Л. Хить Л. Г. Новые данные по дерматографии монголов. Совет. этиограф., 1975 №2
  4. Түмэн Д. Антропология современного населения МНР Лисс, док б. и. 1992
  5. Трепаков Е. А. Кожный рисунок руки: «Наследственность и здоровье» Твое здоровье Ж. 1989 №1, 2, 3, 4, 5, 6
  6. Төмөрбат Н. Гарын хээ «Шинжлэх ухаан амьдрал» 1986 №2
  7. Пүрэвдорж И., Мэндсайхан Г. — Монгол хүний гарын хээ АУИС-ийн багш нарын ЭШ-ний 32-р бага хурлын илтгэлийн хураангуй 1990, 76—78-р тал
  7. Г. Батбаатар, Б. Баярт
  1. Баярт Б. Автореф. дисс. канд. мед. наук. Москва 1989 С 6. 9—17.
  2. Танковская Л. В., Ковальчук Л. В., Баярт Б. Роль эффекторных лимфокинов, регуляции функциональной активности фагоцитарных клеток сбор. науч. труд, Горький 1989. С 85.
  3. Забухин А. А. Бартникий М. И. Цышарина И. А. Реактивность нейтрофилов периферической крови и т ани при хронических бронхитах сбор. науч. труд Горький 1989. С 179.
  4. Иегер Л. Клиническое иммунология и аллергология. Москва М 1990 С 235—251, 379.
  5. Маянский А. Н. Актуальные проблемы фагоцитоза. Сбор. науч. труд Горький 1989 с 5, 11—14.
  6. Шатров В. А. Сравнительное изучение фагоцитарной активности нейтрофилов у больных туберкулезом легких с использованием стафилококков и частиц латекса. Лаб. дело М. 1984 №10 С 614—615.
- Г. Сүхбат, О. Амарцэнгэл
1. Анагаах ухааны дөрвөн үндэс Улаанбаатар 1991 735 с
  2. П. Н. Воробейчик, Е. А. Покитер Основы психогигиены Киев. 1989 183 с
  3. В. И. Вороновская О психофизиологических свойствах и успешности обучения студентов музыкального отделения Конференция «Индивидуальные психофизиологические особенности человека и профессиональная деятельность» Черкассы 1991 г

4. К. Гехт. Психогигиена М. 1979 176 с.
5. Г. И. Зенченко Характеристика индивидуальных особенностей ВНД студентов с ростом спортивного мастерства. — Комференция «Индивидуальные психофизиологические особенности человека и профессиональная деятельность» Черкассы 1991 г
6. Э. М. Казан, Е. С. Гальдшмидт и др. Использование автоматизированных систем для сценка функциональных состояний. Ж. физиология человека 1992, т. 18, №3
7. И. Л. Карцев, Л. Ф. Халдеева, К. Э. Павлович Физиологические критерии профессиоиональной пригодности подростков к различным профессиям. М., 1977. 175 с.
8. Ю. Л. Майдикова, П. П. Майоренко. Роль психофизиологических и личностных особенностей человека в условиях групповой деятельности. Конференция. Индивидуальные психофизиологические особенности человека и профессиональная деятельность. Черкассы 1991 г.
9. Научно-техническая революция: Человек-машина (под ред. К. В. Судакова) М. 1989 192 с
9. А. В. Хватала Э. Санжая Ж. Энхтуул
1. Аветисов Э. С. Охрана зрения детей. —М., 1975 с 272
2. Бейсенбаева Р. А. — Автореф дисс. ...канд мед наук — Алма-Ата 1974
3. Гундорова Р. А., Гришина В. С., Полякова Л. Я., Вильшанский Э. Н., Батраченко И. П. Офтальмол журн., 1982. №7, с. 391—393
4. Гундорова Р. А., Малаев А. А., Южаков А. М. Травмы глаза. —М 1986
5. Зарецкая Ж. М. — Автореф дисс. ...канд мед наук М., 1983.
6. Хватова А. В. Клиника, лечение и исходы проникающих ранений глаз с внедрением инородных тел у детей, — В кн.: Травмы глаз. Профилактика, клиника и лечение. Ученые записки. Вып 16. М, 1970, с. 61—68
7. Т. Булган Хүүхдийн нүдний гэмтлийн байдал. (Монголын нүдний эмч нарын үндэсний семинарын илтгэл) УБ 1990
8. Ж. Тумбааш Монголын Анагаах ухаан сэтгүүл 1978, №4

**1992 ОНД ЭРДМИЙН ЗЭРЭГ ХАМГААЛСАН  
ЭМЧ, МЭРГЭЖИЛТНҮҮД**

**НЭГ. Докторын зэрэг хамгаалсан**

1. Лхамжавын Мягмар, Анагаах ухааны их сургуулийн эмч судлалын тэнхимийн багш.

Сэдэв: Монгол улсын нутгатт ургадаг Азийн төлөгч өвсний бэлдмэлүүдийн фармакологийн судалгаа

Хэзээ, хаана хамгаалсан-1992 оны 6 сар, Москва

Судлаач энэхүү бүтээлдээ Азийн төлөгч өвсний газрын дээд хэсэгт флавоноид  $2,52 \pm 0,003$  г агуулагддагийн дотор 7 төрлийн флавоноид нэгдэл, алколоид, аргаах бодис, витамин С зэрэг байгааг тогтоожээ. Азийн төлөгч өвсний бэлдмэлүүд элэгтний болон чацаархайн бичил цусан хангамжийг сайжруулах, цусны урспалыг түргэсгэх, элэг хамгаалах, исэлдэлт, үрэвслийн зэрэг агчил, тавиулах элгэнд цэс үүсэх үйлдлийт идэвхжүүлэхийн зэрэгцээ цэс хөөх нөлөөтэй болохыг анх удаа тогтоожээ.

Судлаач төлөгч өвсний хуурай экстрактаар «Ахилло» нэртэй бэлдмэл хийсэн нь хуримтлагддагтүй, эмчилгээний хүрээ өргөнтэй, биед болон үр хөврөлд хоргуй болох нь батлагдсан байна.

2. Чүлтэмийн Батмөнх-Анагаах ухааны их сургуулийн мэс заслын тэнхимийн багш.

Сэдэв: БНМАУ-д (хуучин нэрээр) Хэрлэгийн гаралтай зүрхний хоёр хавтаст хавхлагын дутагдалтай гажгийн таркалт, хавхлага солих хагалгаа хийх тухай.

Хэзээ, хаана хамгаалсан: 1992 оны 3 дугаар сарын 13. Москва

Судлаач манай орны хангай, хээр, товийн бусийн хүнэмийн дунд мэс засал хийлгэх шаардлага бүхий хэрлэгийн гаралтай зүрхний гажигтай өвчтөний дундаж тоог тогтоосны зэрэгцээ хэрлэгийн гаралтай хоёр хавтаст хавхлагын дутагдал бүхий өвчинийг оношлох, хагалгаанд сонгон бэлтгэх зарчмыг боловсруулжээ. Түүнчлэн зүрхний хавхлага суулгах мэс ажилбарын үед цусны зохиомол эргэлтийн аппарат ба биений халууныг бууруулах аргыг оновчтой сонирхжээ, зохиомол хавхлагийн төрлийг тохируулах зэрчийг тогтоосны зэрэгцээ хагалгааны дараах үеийн үр дүүргэжиглажээ.

**ХОЁР. Дэд докторын зэрэг хамгаалсан:**

1. Дэмбээгийн Агваандорж—Анагаах ухааны их сургуулийн хүүхдийн өвчин судлалын тэнхимийн багш

Сэдэв: Бага наасны хүүхдийн уушгины цочмог үрэвслийн үеийн хүчил-шүлтийн тэнцвэрийн гажуудал, амьсгалын дутагдлыг оношлох эмчлэх.

Хэзээ, хаана хамгаалсан — 1992 оны 3 дугаар сарын 5 Улаанбаатар.

Д. Агваандорж—энэхүү бүтээлдээ уушгины хурц үрэвсэл бүхий бага наасны хүүхдийн цусны хийн бүтэц, хучилсуурийн тэнцвэрийн үзүүлэлтийг Аструпийн бичил аргаар шинжилсэн материал дээрээ үндэслэн өвчний эмнэлзүйн хэлбэр, уе шат бүрийн амьсгалын дутал, хучил суурийн тэнцвэрт байдлын хэлбийлтийн зэрэг, хэлбэрийн хоорондын хамаарлыг тогтоожээ. Судлаач практикт артерийн цусны хучилтөрөгчийн парциаль даралтын уналтын улмаас суурийн байнгын дутагдал, амьсгалын дутал тургэн үүсч байгааг тогтоож, амьсгалын дутлыг зөвхөн хүнд хөнгөний зогтээр бус, хэлбэрээр нь оноцлохыг, уушгийн хурц үрэвслийн эхэн үед үүссэн хучилшил нь эмнэлзүйн хэлбэр, бие махбодийн урвалж чанар, суурь эмгэгээс хамаарсан суурьшилтад тургэн шилжиж болохыг эмчилгээнд анхаарахыг зөвлөжээ.

2. Сурия Сомди (БНЛАУ)—Анагаах ухааны их сургуулийн аспирант

Сэдэв: Умайн гаднах жирэмсний онош, эмнэлзүй, эмчилгээ

Хэзээ, хаана хамгаалсан: 1992 оны 3 дугаар сарын 19. Улаанбаатар.

Судлаач уг бүтээлдээ умайн гаднах жирэмсний шалтгаан, тохиолдол, хэлбэрийг тогтоож, оношлох шалгуур боловсруулан, энэ эмгэгийн янз бүрийн хэлбэрийн үед хийх эмчилгээний шийдэл, бодлого боловсруулсны зэрэгцээ мэс заслын эмчилгээний дараах хүндэрлээс сэргийлэх эмчилгээний бүрдэл арга, хяналтын шинэ аргачлал боловсруулжээ.

Судлаач умайн гаднах жирэмслэлтийн үед дараах шинж тэмдэгүүд: хэвллийгээр өвдөх (99%), умайн цус алдалт (80%) сарын тэмдэгийн сааталт (62%), цусны эргэлтийн гажуудал (56,6%) тус тус ажиглагдсаныас гадна цус багадалт, ухаан алдалт, огих, бөөлжих, хөхний булчирхай нь томрох шинжуудийн анхаарахыг зөвлөжээ.

3. Мишигдоржийн Оюунбилэг—Эх нялхсын эрдэм шинжилгээний төвийн хоол судлалын секторын эрхлэгч, эрдэм шинжилгээний ажилтан.

Сэдэв: Монгол улс дахь нэг хүртэлх наасны хүүхдийн шүүдэст эмзэгшилийн онцлогууд:

Судлаач уг бүтээлдээ ой хүртлэх наасны хүүхдийн дунд шүүдэст эмзэгшилийн тархалт, түүний үүсэлд нөлөөлж байгаа гадаад, дотоод хүчин зүйлийг тогтоож, шалтгаан, эмгэг жам, шингэний дархлаалыг судлаж, эмчлэх, урьдчилан сэргийлэх аргыг боловсруулжээ.